б. Уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

1.Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Ачит-Ихт ХХК /Катодын цэвэр зэс боловсруулах үйлдвэр/
2.Төслийн байршил: Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт
3.Тусгай зөвшөөрлийн дугаар: UN-000001
4.Огноо: 2023.11.02

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо														
		Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7	Гишүүн 8	Гишүүн 9	Гишүүн 10	Гишүүн 11	Гишүүн 12	Гишүүн 13	Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25	23	23	23	25	23	23	22	20	25	23	23	25	25	23.3	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг сайтар төлөвлөж ажиллах.
2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	30	30	29	25	24	28	28	30	29	30	30	30	30	28.6	Нөхөн сэргээлтийн ажлыг БОНХАЖС-ын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийхэд онцгой анхаарах .
3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний 4төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	9	10	10	10	10	10	10	10	10	9.9	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд тарьсан моднуудын ургалт, хамгаалалтанд онцгой анхаарах. нөлөөллийн бүсийн оршин суугчдаас ажилгүй оролгүй иргэнийг урамшуулах маягаар хамгаалалтыг сайжруулах.

4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, арга хэмжээний биелэлт	**5**	5	5	5	5	5	4	5	5	5	4	5	5	5	**4.8**	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, арга хэмжээг сайтар төлөвлөн БОМТ-д тусгах
5.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	**5**	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Журамд заасны дагуу тухайн жилд Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй учир сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцсон болно.
6.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	**10**	10	10	5	8	10	9	10	10	10	10	10	10	10	**9.3**	Химийн бодисын ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд онцгой анхаарч ажиллах.
7.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	**5**	5	5	4	5	5	5	5	5	5	5	5	5	5	**4.9**	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөг сайтар төлөвлөж ажиллах.
8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	**5**	5	5	3	5	4	5	5	5	5	5	5	5	5	**4.7**	Үйлдвэрийн хяналтын цооногуудад хийсэн шинжилгээний дүнг улирал бүр тогтмол БОАЖГ-т ирүүлж тайлагнаж байх.
9.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	**5**	5	5	4	5	4	4	5	5	5	4	5	5	5	**4.6**	Орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтарч ажлын уялдаа холбоог сайжруулахад онцгой анхаарч байгаа.
10.Аймаг,сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	**5**	5	5	5	5	5	5	4	5	5	5	4	5	5	**4.8**	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах онцгой анхаарч ажиллах.

Нийт 94.9 оноо

Ажлын хэсгийн дарга:
Орхон аймгийн БОАЖГ-ын дарга / С.Жаргалсайхан /

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:
БОАЖГ-ын Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт,байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны бодлогын хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн /О.Цэрэнчимэд/

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХБТХОХ-ийн Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, уул уурхай хариуцсан мэргэжилтэн / У.Чигэстэй /

Байгаль орчин,аялал жуулчлалын газрын геологи, уул уурхай хариуцсан улсын ахлах байцаагч / Д.Сүхбат /

Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч /Д.Жаргал /

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга / С.Отгонбаатар/

ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн / Б.Бүрэн-Эрдэнэ /

БОАЖГ-ын Орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодис, байгалийн гамшиг хариуцсан мэргэжилтэн / П.Энхсэлэнгэ /

СГСГЗ-ны Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн / Н.Эрдэнэчимэг /

Баян-Өндөр сумын байгаль орчны улсын байцаагч /С.Номиндарь/

БОАЖГ-ын байгаль хамгаалагч / Ц.Чинбат/

Нөлөөллийн бүсэд оршин буй иргэдийн төлөөлөл :

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил багийн иргэн /Д.Наранчимэг /

Орхон аймгийн БаянӨндөр сумын Баянцагаан багийн иргэн / Д.Нямсүрэн /

Хүлээн зөвшөөрсөн:

"Ачит-ИХТ" ХХК-ийн үйлдвэрийн захирал / И. Батболд /

АЧИТ-ИХТ ХХК
КАТОДЫН ЗЭСИЙН ҮЙЛДВЭР
АТА7242 ✓ 2788705

AIC
ACHIT IKHT LLC
MEMBER OF LME
An HKEX Company

“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ КАТОДЫН ЗЭСИЙН ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: UN-000001/
/Регистрийн дугаар: 2788705/

Хянасан:

ХБОБНУГ-ын мэргэжилтэн _____ /...../

Биелэлтийг тайлагнасан:

“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрийн захирал _____ /И.Батболд/

“Ачит-Ихт” ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны ажилтан Б. Бүжмаа. /Б.Бүжмаа/

АЧИТ-ИХТ ХХК
КАТОДЫН ЗЭСИЙН ҮЙЛДВЭР
АТА7242 2788705

2023 он

Гарчиг

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн засаг, захиргааны харьяалал

Төслийн байршил: Катодын цэвэр зэс боловсруулах үйлдвэр нь Эрдэнэт хотоос 15 км-т, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр, Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрийн бүсэд байрлана.



Зураг 1. Төслийн байршлын зураг

Төслийн ангилал: Ачит-Ихт ХХК-н үйлдвэр зэсийн бага агууламжтай 2-р овоолгоос L-SX-EW технологи ашиглан катодын цэвэр зэс гаргаж авах төсөл бөгөөд 2014 оноос үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн, тогтмол явагдаж байна.

1.2. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл

Хүснэгт 1. Ачит-Ихт ХХК-ийн аж ахуйн нэгжийн мэдээлэл

Төслийг хэрэгжүүлэгч	Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Төслийн хаяг байршил	Төсөл хэрэгжүүлэгчийн Хаяг байршил
Ачит-Ихт ХХК	9011190055	Орхон аймгийн Баян- Өндөр сумын нутагт байрлах ТӨҮГ-н 2-р овоолгыг түшиглэн катодын зэс үйлдвэрлэх	Эрдэнэт хотоос 15 км, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс 4км-т хойд өргөргийн 49°1'18", Зүүн уртрагийн 104°10'58" координат буюу Орхон аймгийн Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутагт, Төмөр замын Эрдэнэт өртөөнөөс 5км зайд оршино.	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, Кей Би Таур, 21 давхар Утас: 75951155

1.3. Төслийн түүхэн товчоо

Төсөл эхэлсэн огноо: Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь балансын бус хүдрийн хоёрдугаар овоолгод 1978 оноос 2005 оны хооронд 0.307%-ийн агуулгатай 199.230 тн металл зэстэй, 65.0 сая тн хүдэр байршуулсан. "Ачит-Ихт" ХХК хүдрийн нөөцийг шүлтгүйжүүлэлтийн технологиор боловсруулах арга замыг бүх талаас нь судалсны үндсэнд үйлдвэр байгуулах шийдвэр гаргаж, 2014 оны 5/330-14 тоот гэрээгээр 0.31%-ийн агуулгатай 173,998.9 тн металл зэстэй 56.0 сая тн балансын бус хүдрийг шилжүүлэн авсан.

Хүснэгт 2. Үйлдвэрийн түүхий эдийн нөөц, түүнээс гаргаж авах зэсийн хэмжээ:

№	Үзүүлэлт		Нэгж	Хэмжээ
1	Үйлдвэрийн балансад авсан хүдрийн нөөц	Хүдэр	мян. тн	56000.9
		Эзлэхүүн	мян. м³	29699.72
		Зэс	Тн	173998
		Агуулга	%	0.31
2	Үүнээс 1983-2004 оны хооронд угаагдаж ул хөрсөнд суусан зэс		тн	1782
3	2017 оны 7-р сарын 1 -д батлагдсан нөөц овоолгод үлдсэн зэс		тн	135668.8
3.1	Хүдэр		Мян.м3	29699.7
3.2	Исэлдсэн зэс		тн	26219
			%	19.3
3.4	Ашиглалтын бүх хугацаанд гаргах катодын зэс		тн	86056

Төсөл хэрэгжих хугацаа: 52.0%-ийн зэс авалттайгаар 10 жилийн туршид 86056 тн катодын зэс гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн техник эдийн засгийн үндэслэл:

1. 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 14-15-08 тоот дүгнэлтээр хүлээн авч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлын хурлаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших "Ачит-Ихт" ХХК-ийн Катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж. 2014 оны 10 дугаар сарын 28-өдрийн Ашигт малтмалын газрын даргын Т-37 тоот тушаалаар Катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл батлагдсан.
2. 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлын хурлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцүүлэн БҮ-2019-01-01 тоот дүгнэлтээр хүлээн авсан.
3. 2023 онд төслийн техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг бэлтгэж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлын хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

1.4. Төлөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох зөвшөөрлүүд

Хүснэгт 3. Ачит-Ихт ХХК-ийн эзэмшдэг зөвшөөрлүүд, улсын байгууллагын дүгнэлтүүд

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Дугаар	Огноо
1	Аж ахуйн нэгжийн гэрчилгээ	9011190055	2014.02.28
2	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл	0001624 0001625	2020.04.21-2023.12.31
3	Газрын чанарын хянан баталгаа		2015 2020
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт	11/2656 13/4334	2016.05.03 2019.06.20
5	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	БОАЖНХЯ	2016.07.08
6	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	БОАЖНХЯ	2017.05.31 2019.06.18
7	Газар эзэмшүүлэх гэрээ	5/330-14	2014.09.08
8	Ус ашиглуулах дүгнэлт Ус ашиглах гэрээ	01 07	2021.04.02 2022.02.14
9	Химийн бодисын агуулахын магадлалын ерөнхий дүгнэлт	119/2017	2017.04.03
10	Химийн бодисын агуулахын баталгаажуулалт. /Улсын байцаагчийн дүгнэлт/	14-04-004/160	2017.12.12
11	Химийн бодис хадгалах агуулахын байршил тогтоох захирамж	А/640	2014.12.09
12	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт	01804846 - 01804849	2021.02.08-2023.02.08

1.5. Төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт төсөв

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

2019 оны БОАЖ сайдын тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгон ажиллаж байна. 2023 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт 81.166.000 / наян нэгэн сая нэг зуун жаран зургаан мянган / төгрөг төсөвлөж, 5,6 тэрбум төгрөгний зардал бүхий ажлыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын задаргаа, төсөл тус бүрээр

№	Төслийн нэр	Биелэлт /хувиар/	Төлөвлөсөн Зардал	Зарцуулсан төсөв
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	100	8'500'000	16'550'000
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	100	17'800'000	18'000'000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	100	14'500'000	75'500'000
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	100	1'000'000	1'000'000
5	Хог хаягдлын менежмент	100	29'486'000	46'723'500
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	100	1'000'000	1'000'000
7	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	100	Тогтсон зардлаар	2'763'200'000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	100	8'880'000	7'880'000
Нийт		**100**	**81'166'000**	**2'929'853'500**

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ бүлгийн зорилго нь төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, үргэлжлэх эрчим ба цар хүрээг тогтоох нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зорьж ажиллав.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Хувь
	Агаарын чанар			
1	Уурын зуухны үнс утаа	Уурын зуухны утаанд агуулагдах бохирдуулагчийг тодорхойлох	2023 оны 9-10 сард Шилийн Ус ХХК-иар уурын зуухны яндангаар хаягдах утаанд агуулагдах хорт бодисыг тодорхойлуулах ажил хийгдсэн. Нүүрс хэрэглээ- 19.900тн	100
2	Овоолго /бороожуулах, исэлдэх ууршх/	Үйлдвэрийн 6-н байршилд агаарын шинжилгээ хийлгэх	УЦУОШТ гэрээний дагуу агаарын дээж авч шинжилгээ хийсэн.	100
3	Агаарын бохирдол бууруулах	Үйлдвэрлэлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд янданд Орчны агаар дахь тоосжилт болон хүхэрлэг хийг тодорхойлуулсан.	Эрүүл ахуй, хор судлалын лаборатори ХХК—мар хийлгэсэн.	100
	Гадаргын ба газрын доорхи усны нөөц			
4	Хаягдал усны шинжилгээ хийлгэх	Цэвэрлэгдсэн бохир усанд хөндлөнгийн хяналт шинжилгээг хийлгэх.	Хаягдал усны шинжилгээг төлөвлөгөөний дагуу улирал тутамд хийлгэсэн.	100
5	Овоолгоос урсах уусмал	Гүний усанд нэвчилт үүсэж байгаа эсэхт хяналт тавих	Гүний усны тогтмол 7 хоногийн мягмар гариг бүр шинжилгээ хийсэн.	100
6	Цөөрөм	Цөөрмийн налуугийн хяналт тавих	Цөөрмийн налуугийн хяналт тавьж тогтмол хугацаанд 26 удаа 208 үзлэг хийсэн.	100
	Хөрсөн бүрхэвч			
7	Хөрсөнд хаягдал тос асгарах	Хаягдал шатах, тослох материалыг тусгайлан тосон авч, зөвшөөрөл бүхий байгууллагад хүргүүлэх	Хаягдал шатах, тослох материалыг тусгайлан тосон авч, зөвшөөрөл бүхий "Монпити Ойл" ХХК-д гэрээний дагуу 2023 онд 800л тос шилжүүлсэн.	100

8	Хуурайшилт ихтэй үед замын тоос босох	Замыг усалж тоос дэгдэхээс сэргийлэх	Замыг усалж тоос дэгдэхээс сэргийлж "Далайн хошууны шинэс" ХХК -тэй гэрээ байгуулж 6,7,9,10 дугаар саруудад зам усалгааг өдөр бр хийсэн.	100
9	Уусмал хөрсөнд нэвчих	Хөрсөн бүрхэвчийн 5 хяналтын цэгээс хүнд болон бусад элемент тодорхойлох	Хөрсөн бүрхэвчийн 5 хяналтын цэгээс гадна нэмэлт 5 цэгт жилд 2-р удаа хүнд болон бусад элементийн хөндлөнгийн шинжилгээ SGS, хяналтын төв лабораторит хийлгэсэн.	100
	Газрын хэвлий			
10	Үйлдвэрийн бүсд хатуу хог хаягдал үүсэх	Эко өдөрлөгийг тогтмол хэрэгжүүлэх	Эко өдөрлөгийг 10-дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан.	100
11	Газрын хэвлий хөндөхөөс сэргийлж	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж "Ухалт малталтын ажлын зөвшөөрөл"-ийг холбогдох журмын дагуу өгч, бүртгэл хөтлөх	"Ухалт малталтын ажлын зөвшөөрөл"-ийг холбогдох журмын дагуу тогтмол бүртгэл хөтөлж ажилласан.	100
	Уур амьсгал			
12	Хур бороо, үер буух	УЦУОШГ-тай хамтарч мэдээллийн сан үүсгэх. Бороо ус ихтэй үед урьдчилан сэргийлэж тогтмол цаг агаарын мэдээ авах	Сар бүрийн цаг агаарын урьдчилан мэдээ авч хур борооны үерээс сэргийлэж ажиллав.	100
	Нийт	**8'500'000**	**16'550'000**	100

Жич: Үйл ажиллагааны зардалд тусгасан зардал нь "Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд" ороогүй болно. ОХШХ-т тусгасан зардал нь 9 дугаар бүлэг дэх Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан болно.

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Техникийн нөхөн сэргээлт нь биологийн нөхөн сэргээлт буюу биологийн олон төрөл зүйл тухайн газар эргэн нутагших экосистемийг сэргээх цогц үйл ажиллагааны үндэс суурь болдог. "Ачит-Ихт" ХХК нь техникийн нөхөн сэргээлтийг цаг тухайд нь хариуцлагатай гүйцэтгэхийг эрмэлзэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2023 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж үйлдвэрийн орчим мод тарьж ногоон бүс байгуулахаар зорьж байна.

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Хувь
2	Биологийн нөхөн сэргээлт	Үйлдвэрийн хашаанд зам дагуу хайлаас мод суулгах	Үйлдвэрийн талбай орчимд нийт 230,000ш хайлаас, улиас 66ш нарс мод суулгав.	100
	Нийт	**17'800'000**	**18'000'000**	100

"Ачит- Ихт" ХХК нь 2014 оноос эхлэн "Бүх нийтээр мод тарих" үндэсний өдрийг тэмдэглэн үйлдвэрийн талбайд ногоон байгууламж байгуулах ажлыг ажилтнууд болон гэрээт мэргэжлийн байгууллагатай хамтран өрнүүлэхээс гадна тус үйл ажиллагааг өргөжүүлэн тэлж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангитай хамтран өөрийн компанийн нэрэмжит төгөлтэй болох зорилгоор Сархиа уул, хотын А1001 зам дагуу мод тарих ажлуудыг зохион байгуулж байна. 2023 онд үйлдвэр орчимд 230.000ш хайлаас, улиас модыг үрсэлгээ болон харандаа хэлбэрээр, 66ш нарсыг үйлдвэр дотроо, 8000ш моддыг А1001 хайлаасыг зам дагуу, 1144ш бургасыг хотын хаалганы орчимд голын голвдрол дагуу тус тус тарьсан.

Мөн тус онд үйлдвэр орчимд болон мод үржүүлгийн талбай, А1001 зам дагуух талбайд тарьж ургуулсан нийт моддын амьдралт, ургалт, арчилгаанд МУИС- хүрээлэн буй орчин ойн инженерчилэлийн тэнхимийн доктор, дэд профессор С. Гэрэлбаатараар мониторинг хийлгэсэн. Дүгнэлтээр: "Ачит-Ихт" ХХК өнгөрсөн хугацаанд навчит болон шилмүүст үүлдрийн нийт 15 зүйлийн 8510 ширхэг модлог ургамлыг амжилттай тарьж ургуулсан бөгөөд таримал модны 91.1%-ийг навчит, 8.9%-ийг шилмүүст мод эзэлж байна. Таримал моддын амьдралтын хувь харилцан адилгүй байгаа бөгөөд навчит модны амьдралтын хувь харьцангуй өндөр, моддын өсөлт хөгжилт хангалттай сайн байна" гэж тодорхойлогдсон.

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

"Ачит- Ихт" ХХК-ийн катодын зэс ялган авах төсөл нь нутгийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна. Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох эрсдэл буюу болзошгүй сөрөг нөлөөллийг шатлалтайгаар бууруулах зарчмыг баримталж зохион байгуулах.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар Зарлигийн дагуу "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд" 2022-2030 онд 3,0 сая модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын төслийг боловсруулан Орхон аймагт хэрэгжүүлж, ажиллаж байна.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Гурван замын ногоон зурвасанд 2019-2021 онд тарьсан моднуудын ургалт, хамгаалалтанд онцгой анхаарч нөхөн тарилт болон хамгаалалтын хашааг засварлаж шинэчлэх	Хамгаалалтын хашааг хавар, намар 2 удаа засаж, хүчитгэсэн. 8000ш хайлаас шинээр суулгасан.	100
2	Булаг шандын эхийг хамгаалах	Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр дэх Хөөврийн рашааны усны хими, физик, бактериологийн шинжилгээг хийлгэж, тогтмол хяналт тавин хамгаалалтын хашааг засварлаж шинэчлэх.	МХГ- шинжилгээ хийлгэж, тохижилт засвар хийсэн.	100
3	Суулгац бэлдэх	Модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх.	Мод үржүүлгийн газар байгуулж, 300,000 мянган үрсэлгээ үрслүүлэв.	100
4	Мод тарих	Хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдээр Эрдэнэт шинэ хаалганаас буюу А1001 авто зам дагуу 3-н замын пост хүртэл ногоон зурвас байгуулж навчит мод тарьж ургуулж хамгаалах.	Шинэ талбайд хамгаалалтын хашааг барьж, 1144 ш бургас мод Хотын хаалганы орчим, голын гольдрол дагуу суулгав.	100
	Нийт	**14'500'000**	**75'500'000**	100

"Ачит-Ихт" ХХК нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас газар ашиглах гэрээний дагуу 157.16 га талбайг ашиглах зөвшөөрөлтэй ба нийт 156.96 га талбай ашиглалтын идэвхтэй хэлбэрт байна.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Гамшгийн үед компанийн үйлдвэрийн оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ба гамшгийн эрсдэлд өртөж эрүүл мэндээрээ хохирох эрсдэлийг даатгалын журмаар зохицуулах ба эрсдэлд өртсөн тохиолдолд хууль тогтоомжийн дагуу нөхөн олговор олгож ажиллав.

Хүснэгт 8. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

№	Төлөвлөгөөтэй эсэх	Хүн, хүчний тооцоо /штаб, мэргэжлийн анги/	Химийн хорт бодисын нэр, тоо хэмжээ	Техник хэрэгсэл		Бэлэн байдлын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /төрөл, тоо ширхэг/						
				3	13	10	100	25	200	1000	20	1
				Автобус	Том оврын болон суудлын тэрэг	Хүчлээс хамгаалах хувцас MSA SAFETY	Резинэн бээлий 20х200	Резинэн гутал	Хошуувч- Р-2	Амны хаалт	Нүүрний хаалт	Хорогдох байр
1	"Ачит-Ихт" ХХК-ний гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу	Удирдлага Штаб: 9хүн Мэргэжлийн анги: 20 хүн	Хүхрийн хүчил: H2SO4 – 6385 тн Органик хандлагч Ликс: 55 тн Кобальтын сульфат: 19тн Гуартек: 4.5 тн Керосин:500 тн									

Нөхөн олговрыг шийдвэрлэх төлөвлөгөө

№	Нөхөн олговрыг шийдвэрлэх арга хэмжээ	Ажилтны тоо	Нэг ажилтны даатгалын зардал	Нийт зардал	Даатгалын компани
1	Ажил олгогчийн даатгал	184	44,861,972	10,462,602,936	Бодь-Даатгал
2	Гэнэтийн ослын даатгал		10,000,000		
3	Эмчилгээний даатгал		2,000,000		
4	Хууль тогтоомжийн дагуу олгох нөхөн олговор	Эрсдэл гарсан үед өртсөн ажилтнуудад нөхөн олговрыг олгоно.			

2023 оны 10 сарын байдлаар үйлдвлэлийн осол огт гараагүй ажилласан бөгөөд ажлын байрны бус эрсдэлд өртсөн нийт 14 ажилтанд хууль тогтоомжийн дагуу Бодь-Даатгалаас 10'011'574 төгрөгийн нөхөн олговор авсан байна

6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК нь МУ-ын хууль, дүрэм журмууд болон олон улсын стандартад нийцсэн компанийн дотоод журмыг боловсруулан хэрэгжүүлэхээс гадна хууль, журмын зүйл заалтын шаардлагын дагуу тухайн жилд хэрэглэсэн Химийн бодисын орлого зарлагын мэдээг тогтмол гаргаж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Цаашид холбогдох баримт бичгийг боловсруулан мөрдлөг болгон ажиллана.

2023 оны байдлаар төслийн хүрээнд нийт 61 нэр төрлийн химийн бодис хадгалагдан, ашиглагдана. Ашиглагдаж буй химийн бодисууд нь бүгд ХАЛМ-тай бөгөөд цаашид шаардлагад үл нийцэж буй ХАЛМ-тай химийн бодис байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана.

Хүснэгт 9. Химийн бодисын менежмент

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Газар зохион байгуулалт, нүүлгэн шилжүүлэх	“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэр нь Эрдэнэт үйлдвэрийн эзэмшлийн бүсэд орших бөгөөд үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртөх байнгын оршин суугч байхгүй.	Үйлдвэрийн 184 ажилтан даатгалтай бөгөөд 2023 онд 14 ажилтан даатгалын нөхөн олговор авсан байна.	100
2	Гамшиг ослын эрсдэл	Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж штаб, албадыг бэлтгэл сургуулилтаар хангана.	2023 оны 6р сард гамшгийн аюулын дуут дохиогоор сургалтыг зохион байгуулсан. Нийт 130 ажилтан хамрагдсан.	100
3	Химийн бодисын ашиглалт тогтмол хяналт тавих	Ажлын хүрээнд ХБ№1-12 маягтын дагуу бүртгэлийг тогтмол хөтлөх. /ХХБАБТХ-13.7, ХБАЗБХ-13/	Химийн бодис тээвэрлэх, буулгах үед тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх журмын дагуу тогтмол хяналт тавьж ажиллав.	100
4	Сургалт	Химийн бодистой харьцан ажилдаг ажилчдад жил бүр химийн бодисын сургалтанд хамруулах	2023 онд нийт 45 ажилтан хамруулсан. Сургалтыг дотооддоо болон хөндлөнгийн байгууллагаас авч байна.	100
5	Химийн бодистой байнга харьцаж ажилладаг ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	Ажлын хувцсаар хангах, эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулах	Баян-Өндр Мед ХХК-нд нийт ажилтнууд эрүүл мэндийн үзлэгт оруулсан бол хэвийн бус ажлын байрны нөхцөлтэй 145 ажилтануудыг биомониторинг шинжилгээнд хамруулсан. Үйлдвэрийн хэмжээнд нийт 203 ажилтан эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан.	100
	Нийт	1’000’000	108’600’000	100

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах, үйлдвэрлэлд ашиглах үед гэнэтийн ослоос эрсдэл үүсэж химийн бодисоор агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрс газрын гадарга бохирдсон тохиолдолд хяналт шинжилгээ хийх, эрсдэлийг арилгах ажлыг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгаж ажиллаж байна.

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн үйл ажиллагааны үед гарсан хог хаягдал:

- Ахуйн хог хаягдал жилд- 439 тн
- Аюултай хог хаягдал жилд- 5670 кг
- Уурын зуухны үнс – 2627тн

Хүснэгт 10. Хог хаягдлын менежмент

№	Нэр	Төлөвлөлт	Биелэлт	Хувь
1	Ахуйн хаягдал	Орон нутгийн эрх бүхий байгууллагатай хог хаягдлыг устгуулах гэрээ байгуулах, журам, нормативын дагуу төлбөрийг төлөх	Орхон аймгийн хот тохижуулах газартай гэрээ байгуулж тогтмол ахуйн хог хаягдлын цэгт тээвэрлэн хүргэж байна. 439тн – 5,048,500төг	100
	Үйлдвэрийн	Уурын зуухны халуун үнсийг өөрийн талбайд хөргөж аюулгүй болсон хойно тээвэрлэн хүргэх.	Орхон аймгийн хот тохижуулах газартай гэрээ байгуулж тогтоосон талбайд тогтмол үнсийг тээвэрлэн хүргэж байна. 2627тн – 32,200,000төг	100
3	Аюултай хаягдал	Тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, тээвэрлүүлэх, устгуулах	Цэцүүх трейд ХХК, гэрээ сунгаж аюултай химийн бодисын аливаа хаягдлыг устгуулсан. 5670кг – 9,475,000төг	100
4	Химийн бодсын хаягдал, крад	Хаягдлыг цуглуулж, овоолго дээрх зөвшөөрөгдсөн цэгт хаях	Нийт 761м3 хэмжээний крадны хаягдал гарч, овоолго дээрх тогтоосон цэгт хүргэгдсэн.	100
5	Дахивар хаягдал	Үйлдвэрийн хэмжээнд хог хаягдлыг тогтмол ангилан ялгаж дахивар хаягдлыг орон нутгийн тээвэр логистикийн төвд тогтмол шилжүүлэх	Хог хаягдлын менежмент нэтрүүлэхээр “Өнгө нэм” ХХК-тай гэрээ байгуулж, ажиллаж байна.	100
6	Сургалт	Хог хаягдлын ангилан ялгалт, байгаль хамгаалах арга хэмжээний талаар сургалт хийх	Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандарт нэвтрүүлэхээр сургалт орсон.	100

7	Хаягдал тос масло	Түр хадгалах, тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, устгуулах.	Монпити ойлтой гэрээг байгуулж түлшний хаягдал тос, масло-ыг устгуулсан.	100
8	Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд эзэнгүй дүүргийн хог хаягдлыг БОАЖГ-н өгсөн саналаар цэвэрлэх		БОАЖГ-н саналын дагуу техник гаргаж ажилласан.	100
Дүн		**22'000'000**	**46'723'500**	**100**

8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 онд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэсэн ба төслийн үйл ажиллагааны хүрээнд цахилгаан станци барих суурь ажлуудыг гүйцэтгэсэн.

Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Нэр	Төлөвлөлт	Биелэлт	Хувь
1	Байгаль орчны аудаит	Байгаль орчны менежементийн тогтолцооны ISO 14001:2015 стандартын магадлах аудит хийлгэх.	Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартын баталгаажуулалтын аудитыг олон улсын TQCSI компаниар хийлгэж, шаардлагад нийцсэн тул стандартын гэрчилгээ сунгагдсан.	100
2	Хаалтын менежментийн төлөвлөгөө	"Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө"-ний бодлогын баримт бичигтэй болсон байна.	Хуулийн шаардлагын дагуу үйлдвэрийн овоолгын хэсэгчилсэн хаалтын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж дуусан. Танилцуулах ажил хийгдэж байна.	100
3	Нарны Цахилгаан станци		Үйлдвэрийн цахилгаан хангамжийн системтэй зэрэгцээ ажиллах нарны цахилгаан станцийг барих ажлыг эхлүүлсэн. 2,7 тэрбум төгрөг.	
Дүн		**20'000'000**	**2'763'382'000**	**100**

8.1.1 Уурхай, Уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу "Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө"-ний бодлогын баримт бичигтэй болсон байна.

Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шаардлагын дагуу ТЭЗҮ-д тусгагдсан ашиглалтын 10 жилийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Хаалт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах шаардлага үүссэн. Бид 2019 оноос хойш судалж, 2022 онд "Грийнлэнд прайндли" ХХК-тай хамтарч ажиллах гэрээ байгуулж хаалтын төлөвлөгөө боловсруулагдсан. Шинжилгээнд Эрдэм шинжилгээний хүрээлэн, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн болон их дээд сургуулийн эрдэмтдээр удирдуулсан баг ажилласан бөгөөд өмнө 2019 онд тус компаний 80 гаруй эрдэмтэн судлаачдаас бүрдсэн баг хамт олон үйлдвэрийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, байгалийн бүрэлдэхүүний үндсэн өгөгдөл, нөлөөллийг нарийвчилан судлах Байгаль орчны цогц судалгааг агаар, хөрс, гүний ус болон овоолго дээрхи, нийт талбайн усны шилжилт хөдөлгөөний тодорхойлох зорилго бүхий геофизикийн судалгааг 1 жилийн турш гүйцэтгэсэн. Тус судалгааны болон бусад холбогдох судалгааны суурь баримт бичгүүдэд тулгуурлан Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. Хаалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг нийт 295'900'000 төгрөгний өртөгөөр гүйцэтгүүлж дууссан. Цаашид сонирхогч талуудад танилцуулах санал авах арга хэмжээг шат дараалан зохион байгуулж байна.

8.1.2 Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, баталгаажуулалтын аудит хийлгэсэн байна.

Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартын баталгаажуулалтын аудитыг компаний бүхий л үйл ажиллагааны хүрээнд олон улсын TQCSI компаниар хийлгэж зөрүү болон зөрчилгүй, сайжруулах саналтайгаар гэрчилгээ сунгагдсан. Гэрээт үнэн дүн 25'944'800 төгрөг /Х24 гэрчилгээ/

8.1.3 Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх замаар цахилгааны хэрэглээгээ бууруулах.

Лондонгийн металлын биржийн гишүүн байгууллага, олон улсын ISO 14001:2015 стандарт нэвтрүүлэгчийн хувьд хүлээсэн үүргийн дагуу сэргээгдэх эрчим хүчийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорьж ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж байна. 2018 онд захиргааны байрны өргөтгөлийг газрын гүний дулаанаар хангах ажлыг, 2022 онд үйлдвэрийн гадна 140ш гэрэлтүүлгийг өөр дээрээ цэнэг хуримтлуулагчтай нарны эх үүсгүүртэйгээр шийдвэрлэсэн бол 2023 онд үйлдвэрийн цахилгааны хэрэглээгээ хэсэгчилж хангах зорилгоор үйлдвэрийн цахилгаан хангамжийн системтэй зэрэгцээ ажиллах 1МВ чадалтай, 2МВт.ц багтаамж бүхий цэнэг хуримтлуур, 2.2МВт-ын нарны цахилгаан станци барихаар төслөө эхлүүлж барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэж байна. Нийт 1.6 сая америк доллар зарцуулагдахаар гэрээ байгуулагдаж энэ онд 2,7 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. /Хавсралт 25 Мэдээлэл/

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлж байна.

“Ачит-Ихт” ХХК орчны хяналт шинжилгээг “Агаар, гүний ус, хөрс”-нд Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албатай хамтран хийж байна. Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу хөрс болон гүний усны хүнд металлын шинжилгээг SGS лаборатори болон ХАНЛАБ лабораториудад хийлгэсэн. Мөн өөрийн лабораторид хуваарийн дагуу 7 хоног бүрт тогтмол дээж авч шинжлэн, хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 12. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
	1. Агаарын бохирдлыг хянах, бууруулах асуудлаар			
1	NO2 SO2	Үйлдвэрийн 6 цэгээс агаарын хяналт хийх. улиралд 1, жилд 24 шинжилгээ	Хуваарийн дагуу улиралд нэг удаа аймгийн УЦУОШТ-с дээж авч шинжилгээ хийсэн. MNS4585:2016 стандартын ЗДХ давсан тохиолдол байхгүй.	100
2	Агаар орчныг бохирдуулагч элементийн хяналт шинжилгээ хийлгэх	Уурын зуухны яндангаас гарах утаанд шинжилгээ хийх байгууллагыг сонгох	Азотын давхар исэл, хүхэрлэг хий, тоосны шинжилгээ хийлгэсэн. MNS4585:2016 стандартын дахь хүлцэх агууламжаас даваагүй байна.	100
3	Цаг уур: агаарын хэм, салхины хурд, харьцангуй чийг, даралт хэмжилтийг тогтмол хийх.		Сар бүрийн нэгэнд тогтмол мэдээ УЦУОШТ-с авсан.	100
4	Орчны агаар дахь тоосжилтын хэмжилт шинжилгээг хийлгэх. (Нийт тоос, Рм 2.5, Рм10)		Консалтингийн байгууллагаар 5 цэгээс шинжилгээ хийлгэсэн.	100
	2. Хөрсний бүхэвч, газар ашиглалт			

5	Хөрсний бүрхэвчийн хяналтын цэгүүдээс дээж авч шинжлүүлэх Тодорхойлох элемент: PH, NH4, SO4, Fe, PO	Үйлдвэрийн хөрсөн бүрхэвчийн хяналтын 5 цэгээс жилд 2-р удаа дээж авч шинжилгээ хийлгэх.	УЦУОШТ хөрсний дээжлэлт хийсэн.	100
6	Элемент тодорхойлох: Cu, Mo, Cd, Zn, As, Pb, Cr, Ni		5 цэгээс хүнд элемент дээж авч хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	100
	3. Гадаргын болон газрын доорх ус			
7	Гүний усны хяналтын цооногуудаас дээж авч хяналт тавих Тодорхойлох элемент: pH, SO4, ЖБ	Гүний усны хяналтын 10 цооногоос сар бүр дээж авч хянах.	Сар бүр аймгийн УЦУОШТ-с гэрээний дагуу ус агуулсан 8-н цооногоос дээжлэлт хийж 96 сорьц шинжилгээ хийсэн.	100
8	Элемент тодорхойлох: Mo, Cd, Zn, As, Pb, Cr, Ni, Cu		8 цэгээс дээж авч SGS лабораторид шинжлүүлсэн.	100
	4. Бусад			
9	Мониторингийн тайланг улирал тутамд БОАЖГ болон Сумын засаг даргын дэргэдэх БО хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэх.		Баян-Өндөр сумын БО хариуцсан мэргэжилтэнд мэдээ хүргүүлсэн.	100
	Дүн	**10,240,000**	**7,880,000**	100

10. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

"Ачит-Ихт" ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төсөл "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үйлдвэрийн бүсэд орших бөгөөд энэ бүсэд байнгын оршин суугч байхгүй хэдий ч Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлууд түүн дотроо орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон нөхөн сэргээлтийн ажлыг тогтмол хэрэгжүүлэхийн ач холбогдол, үр дүнг хэрхэн сум, багийн иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх арга замын талаар орон нутгийн хэлтэстэй ярилцан оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлнэ.

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Биелэлт	Хувь
1	Үйлдвэрийн удирдлагад	Сар улирал тайлагнав	100
2	Компанийн хэмжээнд мэдээлэл, танилцуулга хийх	Хагас жил, жилийн эцэст тайлан бичнэ.	100
3	Баян-цагаан багийн Оршин суугчдад танилцуулах	10 дүгээр сарын 26-ны өдөр үйлдвэрт хүлээн авч үйл ажиллагаагаа танилцуулж, жилийн тайлан хаалтын төлөвлөгөөний явцыг танилцуулсан.	100
4	Орон нутгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт	БОМТ биелэлтийг 11 сарын 2-ны өдөр тайлагнасан.	100
5	Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт	Газар дээрх шалгалт хийсэн.	100
6	Эрх бүхий байгууллагад тайлангаа хүргүүлэх	Тогтоосон хугацаанд	100
	Нийт		100

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1	Шилийн ус ХХК-Уурын зуухны утааны шинжилгээ	X1
2	Агаарын шинжилгээ	X2
3	Тоосны шинжилгээ	X3
4	Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгдсэн усны шинжилгээ	X4
5	Гүний усны шинжилгээ, хүнд металлын шинжилгээ	X5
6	Монпити ойл гэрээ, дагалдах хуудас	X6
7	Зам усалгаа бүртгэл	X7
8	Хөрсний шинжилгээ, хүнд металлын шинжилгээ	X8
9	Эко өдөрлөг тайлан	X9
10	Ухалт малталтын ажлын хяналтын хуудас	X10
11	Хур тунадасны мэдээ авч буй байдал	X11
12	Модны мониторингийн тайлан	X12
13	150ш шинэс мод БОАЖГ-т хүлээлгэж өгсөн акт	X13
14	Хөөвөр шинжилгээнийй хариу	X14
15	Химийн бодисын ачих тээвэрлэх үеийн хяналт	X15
16	Хот тохижуулах газар – Энгийн хаягдлын гэрээ	X16
17	Хаягдал ус зайлуулах зөвшөөрөл	X17
18	Цэцүүх ХХК- аюултай хаягдал	X18
19	Өнгө нэм ХХК- Хог хаягдлын менежмент нэвтрүүлэх ажил	X19
20	Хог хаягдлын сургалтын мэдээлэл	X20
21	Хог хаягдлын тайлан мэдээ - БОХ	X21
22	ISO 14001:2015 стандартын гэрчилгээ	X22
23	Ус ашиглах дүгнэлт, гэрээ	X23
24	Химийн бодис ашиглалтын мэдээ	X24
25	Сэргээгдэх эрчим хүч	X25

1.1. Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000163423

2009.06.08 — / Бүртгэсэн он,сар,өдөр /

9011190055 — / Хувийн хэргийн дугаар /

2788705 — / Регистрийн дугаар /

Ачит-Ихт Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр — / шийдвэрийн нэр /
01 — / дугаар /
2003.09.24 — / он, сар, өдөр /

4610 — Гадаад худалдаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагаины чиглэл /

8299 Ашигт малтмалын үүсмэл ордын ашиглалт /2017.06.22 - 2020.06.22/

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй — / хугацаа /
2 — / гишүүдийн тоо /
100,000.0 — / эрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, стадион орчил, 1, Кэй Би Тауэр, 21-р давхар тоот, Утас1: 75951199, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн бөгөөлөгчийн нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 оны 4 сар 4 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Далдорж овогтой Эрдэнэцэцэг-г гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.*	*2014.03.07*	*Д.Чулуунтуяа*
2	*Дахин гэрчилгээ олгов.*	*2018.04.04*	*Г.Алтан*

* 0 0 0 1 6 3 4 2 3 *

1.3. ҮҮСМЭЛ ОРД АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

"АЧИТ ИХТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭЦЭГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Заспийн газрын II байр, Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81, http://www.mmhi.gov.mn

2017.06.09 № 01/1331

танай 2017.06.06-ны № 1/1226 -т

Санал дүгнэлт хүргүүлэх тухай

Танай компаниас ирүүлсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргуулах хүсэлт, холбогдох бусад баримт бичгийг тус яамнаас байгуулагдсан ажлын хэсэг судлан үзэж танилцлаа.

"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд танай компанид үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгоход тус яамны зүгээс татгалзах зүйлгүй болно.

Иймд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журмын 4.1-д заасны дагуу үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг холбогдох бусад баримт бичгийн хамт Ашигт малтмал, газрын тосны газарт гаргах, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ чанд биелүүлэн ажиллах нь зүйтэй.

Ц.ДАШДОРЖ

08 0636

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛЫН ҮЙЛДВЭР ОРДЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***UN-000001***

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийн 26.11-т заасныг үндэслэн

Орхон аймаг /хот/-ийн

Баян-Өндөр, Жаргалант сум /дүүрэг/-ын

Эрдэнэтийн овоо нэртэй газарт орших

111.68 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нохцөл, шаардлагын дагуу үйлдвэр ордыг ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн ***9011190055*** тоот гэрчилгээтэй

"Ачит-Ихт" ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг ***2020.06.22*** дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчинтэй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХТАМИР

2017 оны 06 сарын 22 өдөр

Улаанбаатар хот

0000001

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

UN-000001

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-UN	• Бүртгэв: Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгосон 2017.06.22, дуусах хугацаа 2020.06.22 • Кадастрын хэлтсийн даргын 2017.06.22-ны 362 тоот шийдвэр	2 2017-06-22 КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595
002-UN	• Бүртгэв: Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн солбицолд өөрчлөлт оруулав. • Кадастрын хэлтсийн даргын 2017.10.12-ны 613 тоот шийдвэр	3 2017-10-16

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

UN-000001

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг						
				#	Уртраг			Өргөрөг		
002-UN	• Бүртгэв: Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн солбицолд өөрчлөлт оруулав. • Кадастрын хэлтсийн даргын 2017.10.12-ны 613 тоот шийдвэр	115.91 Га	0 Га	1	104	10	22.21	49	1	0.58
				2	104	9	54.58	49	1	0.48
				3	104	9	52.53	49	1	0.79
				4	104	9	48.72	49	1	2.48
				5	104	9	45.6	49	1	5.01
				6	104	9	44.51	49	1	6.32
				7	104	9	44.05	49	1	7.01
				8	104	9	46.44	49	1	7.4
				9	104	9	44.19	49	1	8.29
				10	104	9	45.23	49	1	11.93
				11	104	9	45.73	49	1	13.01
				12	104	9	46.42	49	1	15.87
				13	104	9	48.58	49	1	17.68
				14	104	9	19.88	49	1	24.82
				15	104	9	18.82	49	1	26.14
				16	104	9	17.18	49	1	26.97
				17	104	9	15.47	49	1	27.32
				18	104	9	14.7	49	1	28.37
				19	104	9	14.63	49	1	30.82
				20	104	9	16.01	49	1	35.48
				21	104	9	17.2	49	1	37.32
				22	104	9	21.51	49	1	39.5
				23	104	9	23.04	49	1	40.77
				24	104	9	29.44	49	1	40.46
				25	104	9	33.26	49	1	39.91
				26	104	9	34.45	49	1	39.66
				27	104	9	35.95	49	1	39.27
				28	104	9	40.21	49	1	38.65
				29	104	9	43.74	49	1	36.93
				30	104	9	48.37	49	1	43.66
				31	104	9	50.22	49	1	44.54
				32	104	9	53.68	49	1	44.07
				33	104	9	57.43	49	1	40.61
				34	104	10	8.37	49	1	38.87
				35	104	10	11.44	49	1	32.34
				36	104	10	21.73	49	1	28.4
				2017.10.16			Д.Мягмарсүрэн			

XI

"ШИЛИЙН УС" ХХК
"АЧИТ ИХТ" ХХК

"АЧИТ ИХТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГТ БАЙРЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД БАЙРЛАХ УУРЫН ЗУУХНЫ ЯНДАНГААР ХАЯГДАХ УТААНД АГУУЛАГДАХ ХОРТ БОДИСЫН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН ТАЙЛАН

Захиалагч: "Ачит Ихт" ХХК-ийн үйлдвэрийн
үйл ажиллагаа эрхэлсэн захирал И.Батболд

Ерөнхий инженер Ц.Галсүрэн

Дэд бүтцийн менежер Ө.Сэлэнгэ

Гүйцэтгэгч: "Шилийн Ус" ХХК-ийн захирал

Б.Баттөр

Хариуцлагатай гүйцэтгэгч: Доктор (Ph.D) Д.Даваацэрэн

Доктор (Ph.D) А.Түмэнбаяр

Улаанбаатар хот
2023 он

ОРШИЛ

Эрдэнэт үйлдвэр ХХК нь хөвүүлэн баяжуулах технологид тохирохгүй, ядуу агуулгатай балансын бус, холимог хүдрийг 1978 оноос 2004 он хүртэл 2-р овоолгод тавьсан. **Ачит-Ихт ХХК** нь балансын бус хүдрийн 2-р овоолгыг ашиглан, үйлдвэр байгуулах хамтын ажиллагааны гэрээг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-тай 2010 онд хийсэн байна. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед **ТЭЗҮ**-ийг нийт 4 удаа боловсруулж 2014 онд ТЭЗҮ-ээ ЭБМЗ-өөр батлуулсан бөгөөд 2018 онд Үүсмэл ордын нөөцийг ашигт малтмалын **Улсын нөөцийн нэгдсэн санд** бүртгүүлж, **2019 онд ТЭЗҮ тодотголыг** батлуулсан.

Эрдэнэт үйлдвэрийн 2-р овоолгыг ашиглан катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг "Ачит Ихт" ХХК барьж байгуулан ашиглалтад оруулсан байна. Тус компани нь Эрдэнэт үйлдвэрийн 2-р овоолгыг уусган баяжуулах технологи ашиглан катодын зэс үйлдвэрлэн экспортод гаргаж байгаа бөгөөд тус компанийн үйлдвэрт шаардлагатай технологийн уурыг SZL8-1.25-AII маягийн 2 уурын зуух суурилуулан хангаж байсан бөгөөд 2018 онд SZL8-1.25-AII маягийн 2 уурын зуухаар өргөтгөл хийн ажиллаж байна.

Шинээр суурилуулсан хүрэн нүүрсээр ажиллах SZL8-1.25-AII маягийн технологийн уурын зуух нь Бээжин хотын эрчим хүч хэмнэлтийн болон хүрээлэн байгаа орчныг хамгаалах төвүүдийн туршилтын үр дүнгээр үйлдвэрлэгдсэн бөгөөд түүний экологийн үзүүлэлтүүд нь зуухны ашиглалтын явцад ялгаруулж байгаа бохирдуулагч бодисуудын гаралтын стандартын (DB11/139-2002) шаардлагад нийцсэн үнэлгээ авсан байна. Зуухны ашигт үйлийн коэффициент 81.86 % гэж заасан байгаа бөгөөд зуух тус бүр нойтон үнс барих төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

Катодын зэс боловсруулах үйлдвэрийн технологийн уурын зуухнууд нь С6-41 маягийн үлээх салхилуурттай бөгөөд 9369-18137 $м^3$/ц бүтээмжтэй, 2635-3391 Па напортой, 18,5 кВт-ын, 0.4 кВ, 35,8 А, 1470 эрг/мин цахилгаан хөдөлгүүртэй бөгөөд 91.2 % ашигт үйлийн коэффициент, утаа сорогч нь 21578-41773 $м^3$/ц бүтээмжтэй, напор нь 2764-3697 Па, цахилгаан хөдөлгүүр нь 45 кВт, 0.4 кВ, 85,4 А, 1480 эрг/мин, АУК нь 93,1 % тус тус байна. Эдгээр зуухнуудын утаа сорогчууд нь 200 °С температурт ажиллах боломжтой гэсэн байна.

SZL8-1.25-AII маягийн зуухнаас хаягдах утааны хий дэх бохирдуулагч бодисын хэмжээг тодорхойлох туршилтыг 2023 оны 9 сарын 15-ны өдрийн .....тоот гэрээний дагуу хийсэн бөгөөд туршилтаар зуухны утааны хийтэй хаягдаж байгаа бохирдуулагч бодисуудыг тодорхойлж өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулсан болно.

5. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

SZL8-1.25-AII маягийн уурын зуухны утааны хийн хэмжилтийг хийж, хэвийн нөхцөлд шилжүүлэн тооцож, Монгол улсын үндэсний стандарт MNS 5919:2008 -тай харьцуулан дараах дүгнэлтүүдийг гаргав.

1. Шаталтаас үүсэх утааны хийн найрлага дахь бохирдуулагч бодисуудын хэмжээг үндэсний стандарттай харьцуулахад нүүрстөрөгчийн дутуу исэл 1-р зууханд **2.94..53.9** дахин бага, азотын исэл **10.2...14.5** дахин бага, хүхрийн давхар исэл 11.7...12.7 дахин бага, дэгдэмхий үнс, тоос **65.7...250** дахин бага байсан бол 4-р зууханд нүүрстөрөгчийн дутуу исэл **2.3...4.25** дахин бага, азотын исэл **9.79...15.9** дахин бага, хүхрийн давхар исэл **9.47...15.9** дахин бага, дэгдэмхий үнс, тоос **19.05...105.6** дахин бага байгаа нь нойтон үнс баригчийн ажиллагаа сайн байгааг харуулж байна.
2. Эдгээрээс дүгнэхэд SZL8-1.25-AII маягийн уурын К-1 ба К-4 зуухнуудын түлшний шаталтаас үүсэх бохирдуулагч бодисуудын хэмжээ Монгол улсын үндэсний стандарт **MNS 5919:2008** заасан утгаас бага байгаа тул уг зуухнууд нь стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.
3. Дээрх зуухнуудын хэмжих хянах багажнуудыг хянан баталгаажуулалт тогтмол хийлгэж байх, түлшний шаталтын горим, түлш агаарын харьцаа, утаа сорогчийн соролтыг тохируулж, мэргэжлийн байгууллагаар дулаан техникийн туршилт хийлгэж, зуухны горимын түр карт боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай. Ингэснээр зуухнаас хаягдаж байгаа агаар бохирдуулагч бодисуудын хэмжээг нормт хэмжээнд барьж ажиллах боломж бүрдэнэ.
4. Үйлдвэрлэлийн технологийн процессын үед эрчим хүчний үйлдвэрүүдэд мөрдөх ёстой ААД (Аюулгүй ажиллагааны дүрэм), ТАД (Техник ашиглалтын дүрэм) болон ХАБЭА-н шаардлагыг өндөр түвшинд мөрдөн ажиллаж байгаа нь техник ашиглалтын түвшин нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлж байгаа боловч мэргэжилтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

5. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

"Ачит Ихт" ХХК-ийн Эрдэнэт дахь зэсийн үйлдвэрийн зуухнуудаас орчинд хаягдаж буй утааны хийн найрлагыг тодорхойлох ажлын үед зуухны дотоод үзлэг хийх боломж олдоогүй ба гадаад үзлэг болон туслах тоноглолуудад хийсэн үзлэгээс цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээнүүдийн жагсаалтыг гаргалаа. Үүнд:

- Зуух, технологийн шугам хоолойд гидравлик тооцоо хийж зуухны ажлын параметрүүдийг бүрэн гаргахуйц нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай ба үүний зэрэгцээ нүүрсний зарцуулалтыг нарийн хэмждэг болох хэрэгтэй.
- Мөн үйлдвэрлэлийн хэрэглэгч бүрийн дулааны хэрэглээг нарийвчлан тооцоолж, тэдгээрийн дулааны хэрэглээний ачааллын график байгуулан, гидравлик тооцоонд үндэслэсэн гидравлик горимын картыг мөрдөн ажиллах хэрэгтэй.
- Үнс баригчийн хувьд түүний гарах талд тосгуур (буюу чайник) байхгүй, мөн түүний усны түвшин бага байгаа учраас үнс баригч хий соролт ихтэй байгаагаас утаа сорогчийн ачааллыг нэмэгдүүлж байна. Түүнээс гадна тунгаалтын хэмжээ сайн хийгдэж чадахгүй, үнстэй усаар рециркуляци хийж байгаа нь түүний насосны ажиллагаанд муугаар нөлөөлж байгаа бөгөөд тунгаах бакны эзлэхүүнийг нэмэгдүүлэн үнсгүй, тунгаагдсан усаар рециркуляци хийдэг болгох, мөн хатуулаг багатай усыг үнс баригчид өгдөг болгох нь элэгдлийн зардлыг бууруулна.
- Үлээх салхилуур болон утаа сорогчийн ажиллагааг удирдах зорилгоор инвертер суурилуулсан нь сайшаалтай боловч түүний ачааллын характеристикуудыг гарган авч, мөрдөн ажиллах шаардлагатай. Ингэснээр дотоод хэрэгцээний ЦЭХ-ний хэмжээг боломжит хэмжээнд хүртэл бууруулах нөхцөл бүрэн хангагдана.
- Дээр дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дараа зуухны ажиллагааны горим, тохируулгын туршилт хийлгэж зуухны хүчин чадал, ашигт үйлийн коэффициент тодорхойлох шаардлагатай. Ингэснээр зуухны ажиллагааны үед барьж ажиллах горимын карттай болсноор зуухны ашиглалтын ажиллагаа дээшлэх юм.

УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ
Орхон аймаг, Баянцагаан баг,
Тосгон Утас/Факс: 70357258
E-mail:orkhon@namem.gov.mn

№26

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№	: 2023.06
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: Ачит-Ихт ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Г.Банзрагч /техникч/
Сорьцын тоо, төрөл	: 6, агаар
Сорьц авсан огноо	: 2023.06.19
Шинжилгээний дүн өгсөн огноо	: 2023.06.20
Сорьцын тодорхойлолт	: Агаарын шинжилгээний сорьц
Шинжилсэн огноо	: 2023.06.19
Хуудасны тоо	: 1/1

Шинжилгээний аргачлал		Шинжилсэн үзүүлэлт	Цэгийн нэр						ЗДХ MNS4585:2016
			SX	PLS	Харуулын байр	Уусгалтын талбай	Уурын зуух	Хүчлийн агуулах	
MNS...	17.2.5.12:88	SO_2 мкг/м³	0.013	0.005	0.006	0.012	0.006	0.007	450
	17.2.5.11:88	NO_2 мкг/м³	0.013	0.024	0.056	0.021	0.040	0.011	200

Шинжилгээ гүйцэтгэсэн техникч. Г.Банзрагч
Хянасан инженер. Н.Энхмаа

Хянасан: БО-ны хяналтын улсын ахлах байцаагч Д. Сүхбат

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын үр дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ҮНИЙН САНАЛ

Дугаар: OHS23169 R2 Огноо: 6/13/2023

Хэлт энд Сэфти Солушинс ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, УБ Тауэр барилга 7 давхар, 705 тоот, Утас: 7577-9922, Имэйл: contact@hss.mn, Вэбсайт: hss.mn

ISO/IEC 17020 ИТГЭМЖЛЭГДСЭН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГА

Үнийн санал авсан байгууллага

"Ачит ихт" ХХК

Харилцах ажилтан: Байгаль орчны ажилтан, Б.Бүжмаа

Утасны дугаар: 99902027, 75951155

Имэйл хаяг: bujmaa.b@achit-ikht.mn

Үнийн санал бэлтгэсэн

Харилцах ажилтан: Б.Дэлгэрхишиг, Эрүүл ахуйн техникийн хяналтын мэргэжилтэн

Утасны дугаар: 94993785

Имэйл хаяг: delgerkhishig@hss.mn

Үнийн саналын 2023 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл

Агуулга: **Агаарын чанарын үнэлгээ хийх үнийн санал**

Д/д	Үйл ажиллагаа	Нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал		Нийт зардал	
1.0	**Орчны хэмжилт шинжилгээ**					**MNT**	**1,644,500**
1.1	Нийт тоосны цуглуулалт, лабораторийн шинжилгээ (MNS 4585:2015 стандартаар)	хэмжилт	5	MNT	90,200	MNT	451,000
1.2	PM 2.5 сорьц цуглуулалт, лабораторийн шинжилгээ (MNS 4585:2015 стандартаар)	хэмжилт	5	MNT	97,100	MNT	485,500
1.3	PM 10 сорьц цуглуулалт, лабораторийн шинжилгээ(MNS 4585:2015 стандартаар)	хэмжилт	5	MNT	97,100	MNT	485,500
1.4	Угаарын хий тодорхойлох сорьц цуглуулалт, лабораторийн шинжилгээ (MNS 4585:2015 стандартаар)	хэмжилт	5	MNT	44,500	MNT	222,500
2.0	**Бусад зардал**					**MNT**	**2,811,000**
2.1	Хэмжилт , сорьц цуглуулалт хийх шинжээчийн ажлын хөлс /Орон нутагт/	хүн х өдөр	1 х 7	MNT	163,000	MNT	1,141,000
2.2	Томилолтын унааны зардал /УБ-Эрдэнэт-УБ/	хүн х удаа	1 х 2	MNT	50,000	MNT	100,000
2.3	Эрүүл ахуйчдын буудлын зардал	хүн х өдөр	1 х 6	MNT	150,000	MNT	900,000
2.4	Томилолтын хоолны зардал	өдөр х удаа	7 х 3	MNT	20,000	MNT	420,000
2.5	Дүгнэлт		1	MNT	250,000	MNT	250,000
* Ажил гүйцэтгэх талбай руу нэвтрэх зөвшөөрөл, шинжилгээ, ажлын талбарт очиж ажиллах үеийн эрүүл ахуйч нарын унаа, байрлах байр, хоолыг захиалагч компаниас хариуцана.			**НИЙТ ҮНЭ**			**MNT**	**4,455,500**
			НӨАТ			**MNT**	**445,550**
			НӨАТ-ТАЙ НИЙТ ҮНЭ			**MNT**	**4,901,050**

Х-4.

MNAS Accreditation system
TL 06-09
MNS ISO/IEC 17025

Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний лавлагаа лабораторийн
Ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

ОРХОН АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хурхайчин баг.
Утас: 70357014

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
боловч эдгээр бохирдуулагч эх үүсвэрийн шууд нөлөөн дор бус (зонхилох салхины чиглэл, тархах орчин) моддын хувьд сөрөг нөлөө хүчтэй илрэхгүй байна.

"Ачит-Ихт" ХХК-ын өнгөрсөн хугацаанд тарьж ургуулсан цөөн тоогоор (20-оос цөөн) тарьж буй жимс, жимсгэний модыг эс тооцвол шилжүүлэн тарьсан навчит модны амьдралтын хувь хангалттай сайн (Шар хуайс 97.4%, Одой хайлаас 91.2%, Азийн монос 98.8%), шилмүүст модноос (Эгэл нарс 80.5%, Сибирь шинэс 73.4%) илүү өндөр байна (Хүснэгт 2). Тус компанийн тарьж ургуулсан моддын амьдралтын үзүүлэлтээс харахад эдгээр зүйлийн модлог ургамлууд Орхон аймгийн байгаль цаг агаарын нөхцөлд тэсвэрлэн ургах боломжтой болох нь харагдаж байна. Харин Агч мод тухайн бүс нутагт өвөлжилтийг тэсвэрлэх чадвар хангалтгүй, өмнөх жилийн өсөлтийн найлзуур бүрэн хатсан ба үндэсний орчмоос шинэ найлзуур дахин түрж ургасан байна.



Зураг 5. Тарьж ургуулсан моддын зүйлийн бүрэлдэхүүний харьцуулалт

Тус компани өнгөрсөн хугацаанд нийт 15 зүйлийн 8510 ширхэг модлог ургамлыг амжилттай ургуулсан байна. Эдгээр таримал моддыг төрөл зүйлийн хувьд авч үзвэл, навчит үүлдрийн мод 91.1%-ийг, шилмүүст үүлдрийн мод 8.9%-ийг тус тус эзэлж байна (Зураг 5). Энэхүү мониторингийн судалгааны дүн навчит мод ойт-хээр, хээрийн хагас хуурай, гандуу уур амьсгалын нөхцөлд дасан зохицож ургах чадвар сайтайг нотлон харуулж буй боловч цаашид тус бүс нутагт дасан зохицож ургах чадвартай шилмүүст модны эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

1. Ачит-Ихт ХХК өнгөрсөн хугацаанд навчит болон шилмүүст үүлдрийн нийт 15 зүйлийн 8510 ширхэг модлог ургамлыг амжилттай тарьж ургуулсан бөгөөд таримал модны 91.1%-ийг навчит, 8.9%-ийг шилмүүст мод эзэлж байна.
2. Таримал моддын амьдралтын хувь харилцан адилгүй байгаа бөгөөд навчит модны амьдралтын хувь харьцангуй өндөр, моддын өсөлт хөгжилт хангалттай сайн байна.
3. "Ачит-Ихт" ХХК-ийн охин компани болох "Далайн хошууны шинэс" ХХК-ийн Мод үржүүлгийн газарт тарьц, суулгацыг их хэмжээгээр ургуулж, материаллаг бааз суурийг бэхжүүлж буй нь цаашид ойжуулалт, нөхөн сэргээлт, агро-ойн зурвас байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын далайцыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.
4. Тус компанийн тарьж ургуулсан моддын амьдралтын хувь, өсөлтийн харьцуулсан дүнгээс үзвэл Орхон аймагт Одой хайлаас, Азийн монос, Шар хуайс, Сибирийн шинэс, Эгэл нарс зэрэг моддыг ногоон байгууламж, ойн зурвас байгуулахад тохиромжтой байна.
5. Таримал моддын эрүүл байдал, ус чийгийн хангамжийг байнга хянаж, шаардлагатай арчилгаа, өвчин хортонтой хийх тэмцлийн ажлыг цаг тухайд нь гүйцэтгэж байх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Мод тарьж ургуулах орчны онцлог нөхцөл, тулгарч болзошгүй эрсдэл, мониторинг судалгааны үр дүнд түшиглэн дараах зөвлөмжийг өгч байна.

Зүйлийн сонголт, тарилтын технологийн талаар:

- Орхон аймгийн байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицон ургах чадвартай Сибирь шинэс, Эгэл нарс, Одой хайлаас, Шар хуайс, Азийн монос, Улиангар, Голт бор, Гүйлс, Бургас зэрэг моддыг үрээр болон вегататив эрхтэнээр тарьж ургуулан шилжүүлэн тарих
- Тарьж буй модлог ургамлын биологийн онцлог, модны хэмжээ, ирээдүйд арчилгаа, механикжуулсан үйл ажиллагаа явуулах боломжийг ханган тарилтыг тодорхой схемийн дагуу гүйцэтгэх нь таримал мод эрчимтэй өсөх, ургах орон зайг хангалттай хэмжээгээр ашиглах, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө нэмэгдэх ач холбогдолтой.
- Хамгаалалтын болон агро-ойн зурвас байгуулах, ойжуулалт, нөхөн сэргээлт хийхэд хөрс боловсруулалтыг цэгэн байдлаар (тарилтын нүх ухаж) хийх тарьц суулгацыг шилжүүлэн тарих (анжисаар хагалсан шанд хайлаасны суулгацыг хэт ойр, маш олон тоогоор тарьсан нь цаашид мод хоорондын өрсөлдөөн хэт их, бүтээмж муутай ой үүсэх эрсдэлтэй)
- Хаврын улиралд тарьц суулгацыг тарих нь тухайн бүс нутагт агаарын харьцангуй чийгшил, хөрсний чийг хамгийн бага, хуурайшилт ихтэй үетэй цаг хугацааны хувьд давхцдаг тул шилжүүлэн тарьсан мод богино хугацаанд үхэж хорогдох эрсдэлтэй. Иймд цаашид хамгаалагдсан үндэсний системтэй буюу бортогонд тарьж ургуулсан тарьцаар ургамал ургалтын хугацааны туршид ойжуулалт, нөхөн сэргээлт, ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэх нь үр дүнтэй. Бортогоны хөрс нь өндөр үржил шим, тохиромжтой бүтэцтэй тул модлог ургамлын суулгацын үндэсний системийн хөгжилд хамгийн тохиромжтой, ус чийгийн багтаамж, тогтоон барих чадварыг бий болгох учир тарилтын дараах стрессийг даван туулах, цаашид эрчимтэй ургах нөхцлийг хангана.
- Үйлдвэрийн хашаанд хүхэрлэг хийн болон усан сан орчмын бохирдлын нөлөөнд өртөж болзошгүй хэсэгт цаашид зөвхөн Одой хайлаас болон Шар хуайс зэрэг навчит мод тарих

Өсөлт бүтээмжийг дээшлүүлэх талаар:

- Тарих модны нүхийг хангалттай хэмжээгээр ухаж, хөрсний үржил шимийн үзүүлэлтээс хамааруулан түүнд компост, бионүүрс болон элс хольж хөрсний үржил шим, сүвшрэл, ус чийгийг тогтоон барих чадварыг нэмэгдүүлэх

- Тарьц суулгацыг ойжуулалт хийх, ногоон байгууламжид шилжүүлэн тарилт хийсний эхний жилүүдэд (3-5 жилд) усалгааг (дуслын усалгааны систем) тухайн зүйл модны биологийн онцлогоос хамааруулан хангалттай хэмжээгээр үе шаттай хийх
- Таримал моддын өсөлтийн явцад фенологийн ажиглалт хийн, шим тэжээл тэжээлийн бодис дутагдах, өсөлт удааширах, навч шилмүүс шарлах шинж тэмдэг илэрвэл шаардлагатай шим бордоогоор бордох
- Ногоон байгууламж болон ойн зурвасад тарьж ургуулсан модны титмийн доод хэсгийн мөчрийн таналт хийн гол ишийг хэлбэржүүлэх замаар таримал модны өндрийн болон хөндлөн өсөлтийг нэмэгдүүлэх, гэмтсэн болон өвчилсөн мөчрийг цаг тухайд нь зайлуулах

Арчилгаа, хамгааллыг сайжруулах талаар:

- Ойжуулсан талбай, ойн зурвас, ногоон байгууламж, мод үржүүлгийн газрыг хашаажуулан таримал моддыг мал, амьтанаас хамгаалах
- Модлог ургамалд физиологийн хөнөөл учруулагч өвчин, хортоны талаар хангалттай мэдлэгтэй байж, хөнөөлийн голомт илэрсэн үед тэмцлийн арга хэмжээг явуулах бодис, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, чадавхийг бий болгох
- Мод үржүүлгийн газарт ургуулж буй тарьц суулгацанд мөөгийн өвчлөлийн голомт үүсэхээс урьдчилан сэргийлж 0.05 хувийн концентрацитай маргенецийн ($KMnO_4$) уусмалаар ургамал ургалтын хугацааны туршид 1-3 удаа шүршин халдваргүйжүүлэх

НОГООН ЗУРВАСТ ТАРЬСАН МОДЫГ ХҮЛЭЭЖ АВСАН АКТ

2023.08.23 № Орхон аймаг

"Ачит-Ихт" ХХК-ний Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 2020 оноос эхлэн А1001 зам дагуу тарьж ургуулсан 150 ширхэг шинэс модны ургалт, арчилгаа хамгаалалт чанар, үр дүн ажлын гүйцэтгэлийг ажлын хэсэг газар дээр үзэж шалгалаа.

Ачит-Ихт ХХК нь Гурван замын уулзварын хойд хэсэг буюу А1001 авто зам дагуу байрлах 0,5га талбайг хашаажуулан стандартын шаардлага хангасан шинэс модны 3-4 настай 150 ширхэг тарьцаар тарьж ногоон зурвас бий болгох ажлыг гүйцэтгэсэн бөгөөд уг тарьсан модны өсөлт хэвийн, ургалт сайн, амьдралтын хувь 90-95 хувьтай ургаж байна. Мөн тус хугацаанд хамгаалалтын хашааг жил бүр хавар намар тогтмол засаж, сайжруулан ажилласан байна. Мөн тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагчид хамтран байнгын ажиглалт хийж ажилласан байна.

АЖЛЫН ХЭСГЭЭС ӨГӨХ ЗӨВЛӨМЖ:

1. "Ачит-Ихт" ХХКомпаний Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд А1001 зам дагуу тарьж ургуулсан модны ургалт сайн байгаа боловч хамгаалалтыг илүү сайжруулах шаардлагатай байгаа тул арчилгаа, хамгаалалтын ажлыг үргэлжлүүлэн 2026 оныг дуустал 3 жилийн хугацаанд хариуцан ажиллах.

АКТ ҮЙЛДСЭН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ОСОРЖАМАА

АКТ ТОГТООСОН:

ЗАХИАЛАГЧ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН

ГҮЙЦЭТГЭГЧ

"АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН ХАБЭАБО-НЫ МЕНЕЖЕР Ж.МӨНХДАРХАН

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН Б. БҮЖМАА

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.ЦЭРЭНЧИМЭД

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.ЧИНБАТ

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН ИНЖЕНЕР Ж.АТАРСҮРЭН

2020 оны мод тарилтын байдал



Хашааны бүрэн бүтэн байдал алдагдаж малд идүүлсэн байдал

Хашааг янзлан нөхөн тарилт хийж, дасан зохицсон байдал



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

X15.

MNAS Accreditation system
ЛК 06-09
MNAS/ISO/IEC 17025

ОРХОН АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг.

Утас: 70357914

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар */Registration number/* : 23-471
Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : Ачит Ихт ХХК
/The name of customer's request for analysis/
Дэд лабораторийн нэр */Name of the sub laboratory/* : Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори; Эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лаборатори

Дээжийн тодорхойлолт */Sample description/*					
Дээжийн дугаар *Sample number*	**Дээжийн нэр** *Name of sample*	**Цувралын дугаар** *Batch number*	**Үйлдвэрлэсэн улс** *The country of original manufacturer*	**Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа** *Date of expiry*	**Дээжийн тоо хэмжээ** *Quantity of the sample*
1469	Шугамын ус -Хөвөг		Монгол Улс	Тодорхойгүй	1.0 л

Хүлээн авсан огноо *Date of receipt*	**Шинжилгээ дууссан огноо** *Date of test completion*	**Хэвлэсэн огноо** *Date of issue of the report*
2023 он 06 сар 07 өдөр	2023 он 06 сар 12 өдөр	2023 он 11 сар 01 өдөр

Дээжийн дугаар *Sample number*	**Шинжилгээний аргын стандарт** *Method of analysis*	**Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж** *Test parameter, unit*	**Шаардлага** *Test specification, unit*	**Шинжилгээний дүн** *Test results*
1469	MNS ISO 6222:1998	*ББЕТ*	1мл-т 100	26
	MNS ISO 19250:2017	*Salmonella spp*	25мл-т илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	100мл-т илрэхгүй	Илрээгүй
	MNS 1097:1970	Аммони	<1.5 мг/л	0.01мг/л
	MNS 1097:1970	Кальци ион	<100.0 мг/л	40.1 мг/л
	MNS 1097:1970	Магни ион	<30.0 мг/л	14.6 мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	<0.3 мг/л	0.03 мг/л
	MNS 1097:1970	Нитрат ион	<50.0 мг/л	9.1 мг/л
	MNS 6779:2019	Нитрит ион	<1.0 мг/л	илрээгүй
	MNS ISO 10523:2001	pH	6.5-8.5	7.7
	MNS 6271:2011	Сульфат ион	<500.0 мг/л	22.1 мг/л
	MNS ISO 6878:2011	Фосфат ион	<3.5 мг/л	илрээгүй
	MNS 6272:2011	Фтор ион	<0.7-1.5 мг/л	илрээгүй
	MNS 6778:2019	Хатуулаг	<7.0 мг*экв/л	3.2 мг*экв/л
	MNS 4424:2005	Хлорид	<350.0 мг/л	7.1 мг/л

Санал тайлбар:
Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН
Approved by ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: *гарын үсэг/signature/* /О .ЗАЯА/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

"АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН ҮЙЛДВЭР

Онц аюултай ажлын зөвшөөрөл **М-01-006-01-I**

№.....

Зөвшөөрсөн Ерөнхий инженер:..... 2025/09/04.

ОГНОО: 2025/09/04.

YAX-01-007-02-I Онц аюултай ажлын жагсаалтаар батлагдсан ажлууд

Энэ зөвшөөрлөөр доор заасан ажлын хүрээнээс гадуур ажил хийхийг хориглох бөгөөд зөвшөөрөл тухайн өдөрт хүчинтэй.

Менежерийн бөглөх хэсэг.

1. Ажлын байрны нэр, гүйцэтгэх ажил: ачуулахаас үйлдвэрлэх HzSO4 3 дэвсгэр засах
2. Ажил гүйцэтгэх хэлтсийн менежер: Ц. Эрдэнэчимэг
3. Хэлтсийн менежерийн томилсон ажил хариуцагч. Албан тушаал: оператор овог нэр: Д. Баяндалай
4. Тухайн ажлыг гүйцэтгэхэд учирч болзошгүй аюулууд.

Ажил хариуцагчын бөглөх хэсэг

№	Аюулууд.	Тийм	Үгүй
1	Өндрөөс унах	✓	
2	Химийн бодис, хорт хийнд хордох	✓	
3	Хөдөлгөөнт тоног төхөөрөмжид мөргүүлэх	✓	
4	Гал гарах, тэсрэх		✓
5	Тохиромжгүй хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэл дутагдалтай		✓
6	Цаг агаарын тохиромжгүй хүнд нөхцөл	✓	
7	Цохигдох, хавчигдах, дарагдах	✓	
12	Хүчдэлд нэрвэгдэх	✓	
13	Живэх	✓	
14	Бүрэн бус техник тоног төхөөрөмж	✓	
15	Ажлын байрны нөхцөл. /Гэрэлтүүлэг, дуу чимээ, тоосжилт, химийн бодисын ууршилт гэх мэт/	✓	

5. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хамгаалах хувцас , хэрэгсэл

№	Хамгаалах хэрэгсэл	Тийм	Үгүй
1	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл /Тухайн ажилд тохирсон ажлын хувцас Ж: химийн хувцас, хучилтөрөгчийн баг гэх мэт/	✓	
2	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	✓	
3	Хамтын хамгаалах хэрэгсэл. /Шатнууд, бэхэлгээний цэг, аврах цагираг гэх мэт/	✓	
4	Өндрөөс уналтаас хамгаалах бүс, хэрэгсэл	✓	
5			
6			

6. Хяналтын арга хэмжээнүүд.

№	Хяналтын арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Гарын үсэг
1	Эрсдлийн үнэлгээ хийгдсэн эсэх гэх мэт		
	Ж-25 Д1-16	Мастер	Б. Алхбаяр

7. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан болон биеийн ерөнхий байдлын үзлэгт орсон ажилтны бүртгэл гарын үсэг.

Ажил хариуцагч, эмч бөглөх хэсэг */Би энэхүү ажлыг гүйцэтгэхэд бүх аюулгүйн шаардлагууд биелэгдсэн гэдгийг зөвшөөрч байна./*

№	Ажил гүйцэтгэх ажилтны овог, нэр	Гүйцэтгэх үүрэг	АА-ны зааврын нэр, дугаар	Зааварчилгаа авсан ажилтны гарын үсэг	Эрүүл мэндийн үзлэг		Алко тест
					Цусны даралт	Эмчийн дүгнэлт	
1	Ц. Енхчимэг	HzSO4-н ачуулах	АА-02-02	Д. Баяндалай	110/80	хэвийн	0
2	Б. Даваасүрэн	Өдрийн хүнтэй	АА-02-10	Б. Даваасүрэн	110/80	хэвийн	0
3	Ц. Цолмон	Засах HzSO4	АА3-02-11	Ц. Цолмон	100/70	хэвийн	0
4		засах					
5							
6							
7							
8							

8. Дээрх шаардлагууд болон хяналтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн ажил хариуцагч ажилтан:

Овог нэр: Б. Алхбаяр Албан тушаал: мастер Гарын үсэг : .....

9. Хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих ХАБ-н ажилтан:

Овог нэр: Н. Энхтөр Гарын үсэг : Н. Энхтөр

10. Зөвшөөрлийг хаасан ажил хариуцагч ажилтан:

Овог нэр:..... Албан тушаал:..... Гарын үсэг : .....

11. Зөвшөөрлийн хуудас хүлээж авсан ХАБ-н ажилтан:

Овог нэр: Н. Энхтөр Гарын үсэг : Н. Энхтөр

Зөвшөөрлийн хуудас бүрэн гүйцэт бөглөгдөөгүй тохиолдолд хүчингүйд тооцно.

"АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН ҮЙЛДВЭР

Онц аюултай ажлын зөвшөөрөл **М-01-006-01-I**

№.....

Зөвшөөрсөн Ерөнхий инженер:..... 2026/09/01 ОГНОО:/2026/09/01

ҮАХ-01-007-02-I Онц аюултай ажлын жагсаалтаар батлагдсан ажлууд

Энэ зөвшөөрлөөр доор заасан ажлын хүрээнээс гадуур ажил хийхийг хориглох бөгөөд зөвшөөрөл тухайн өдөрт хүчинтэй.

Менежерийн бөглөх хэсэг.

1. Ажлын байрны нэр, гүйцэтгэх ажил: H_2SO_4 - Агуулахаас үйлдвэрлэл зогсох (7 удаа)
2. Ажил гүйцэтгэх хэлтсийн менежер: Ж. Отгонбаатар
3. Хэлтсийн менежерийн томилсон ажил хариуцагч. Албан тушаал: Оператор ..... овог нэр: Д. Ерөөлт
4. Тухайн ажлыг гүйцэтгэхэд учирч болзошгүй аюулууд.

Ажил хариуцагчын бөглөх хэсэг

№	Аюулууд.	Тийм	Үгүй
1	Өндрөөс унах		✓
2	Химийн бодис, хорт хийнд хордох	✓	
3	Хөдөлгөөнт тоног төхөөрөмжид мөргүүлэх	✓	
4	Гал гарах, тэсрэх		✓
5	Тохиромжгүй хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэл дутагдалтай	✓	
6	Цаг агаарын тохиромжгүй хүнд нөхцөл	✓	✓
7	Цохигдох, хавчигдах, дарагдах	✓	
12	Хүчдэлд нэрвэгдэх		✓
13	Живэх		✓
14	Бүрэн бус техник тоног төхөөрөмж		✓
15	Ажлын байрны нөхцөл. /Гэрэлтүүлэг, дуу чимээ, тоосжилт, химийн бодисын ууршилт гэх мэт/		✓

5. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хамгаалах хувцас , хэрэгсэл

№	Хамгаалах хэрэгсэл	Тийм	Үгүй
1	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл /Тухайн ажилд тохирсон ажлын хувцас Ж: химийн хувцас, хүчилтөрөгчийн баг гэх мэт/	✓	
2	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	✓	
3	Хамтын хамгаалах хэрэгсэл. /Шатнууд, бэхэлгээний цэг, аврах цагираг гэх мэт/	✓	
4	Өндрөөс уналтаас хамгаалах бүс, хэрэгсэл	✓	
5			
6			

6. Хяналтын арга хэмжээнүүд.

№	Хяналтын арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Гарын үсэг
1	Эрсдлийн үнэлгээ хийгдсэн эсэх гэх мэт		
	Ж.Б.		

7. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан болон биеийн ерөнхий байдлын үзлэгт орсон ажилтны бүртгэл гарын үсэг.

Ажил хариуцагч, эмч бөглөх хэсэг */Би энэхүү ажлыг гүйцэтгэхэд бүх аюулгүйн шаардлагууд биелэгдсэн гэдгийг зөвшөөрч байна./*

№	Ажил гүйцэтгэх ажилтны овог, нэр	Гүйцэтгэх үүрэг	АА-ны зааврын нэр, дугаар	Зааварчилгаа авсан ажилтны гарын үсэг	Эрүүл мэндийн үзлэг		Алко тест
					Цусны даралт	Эмчийн дүгнэлт	
1	Т. Болормаа	Ерөнхий инженер	АА 02.02		120/80	хэвийн	0
2	Ц. Мөнхбаяр	Бүтээгдэхүүн	АА 02.10		120/80	хэвийн	0
3	Мөнхтөгс	Гэрэлчин	АА 02.11		120/80	хэвийн	0
4		Ж.Б.	07/02/2027				
5		Засварчин					
6							
7							
8							

8. Дээрх шаардлагууд болон хяналтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн ажил хариуцагч ажилтан:

Овог нэр:..Ж.Баяраа..... Албан тушаал:..Оператор..... Гарын үсэг : .....

9. Хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих ХАБ-н ажилтан:

Овог нэр:..Н. Энхтөр..... Гарын үсэг : ..Н. Энхтөр.....

10. Зөвшөөрлийг хаасан ажил хариуцагч ажилтан:

Овог нэр:..... Албан тушаал:..... Гарын үсэг : .....

11. Зөвшөөрлийн хуудас хүлээж авсан ХАБ-н ажилтан:

Овог нэр:..Н. Энхтөр..... Гарын үсэг : ..Н. Энхтөр.....

Зөвшөөрлийн хуудас бүрэн гүйцэт бөглөгдөөгүй тохиолдолд хүчингүйд тооцно.

"АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН ҮЙЛДВЭР

Онц аюултай ажлын зөвшөөрөл **М-01-006-01-I**

№.....

Зөвшөөрсөн Ерөнхий инженер:..... 2025/09/24 ОГНОО: 25.09.01

YAX-01-007-02-I Онц аюултай ажлын жагсаалтаар батлагдсан ажлууд

Энэ зөвшөөрлөөр доор заасан ажлын хүрээнээс гадуур ажил хийхийг хориглох бөгөөд зөвшөөрөл тухайн өдөрт хүчинтэй.

Менежерийн бөглөх хэсэг.

1. Ажлын байрны нэр, гүйцэтгэх ажил:.....
2. Ажил гүйцэтгэх хэлтсийн менежер:.....
3. Хэлтсийн менежерийн томилсон ажил хариуцагч. Албан тушаал:..... овог нэр:.....
4. Тухайн ажлыг гүйцэтгэхэд учирч болзошгүй аюулууд.

Ажил хариуцагчын бөглөх хэсэг

№	Аюулууд.	Тийм	Үгүй
1	Өндрөөс унах		
2	Химийн бодис, хорт хийнд хордох		
3	Хөдөлгөөнт тоног төхөөрөмжид мөргүүлэх		
4	Гал гарах, тэсрэх		
5	Тохиромжгүй хамгаалах хэрэгсэл болон хамгаалах хэрэгсэл дутагдалтай		
6	Цаг агаарын тохиромжгүй хүнд нөхцөл		
7	Цохигдох, хавчигдах, дарагдах		
12	Хүчдэлд нэрвэгдэх		
13	Живэх		
14	Бүрэн бус техник тоног төхөөрөмж		
15	Ажлын байрны нөхцөл. /Гэрэлтүүлэг, дуу чимээ, тоосжилт, химийн бодисын ууршилт гэх мэт/		

5. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хамгаалах хувцас , хэрэгсэл

№	Хамгаалах хэрэгсэл	Тийм	Үгүй
1	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл /Тухайн ажилд тохирсон ажлын хувцас Ж: химийн хувцас, хучилтөрөгчийн баг гэх мэт/		
2	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл		
3	Хамтын хамгаалах хэрэгсэл. /Шатнууд, бэхэлгээний цэг, аврах цагираг гэх мэт/		
4	Өндрөөс уналтаас хамгаалах бүс, хэрэгсэл		
5			
6			

6. Хяналтын арга хэмжээнүүд.

№	Хяналтын арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Гарын үсэг
1	Эрсдлийн үнэлгээ хийгдсэн эсэх гэх мэт		

7. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан болон биеийн ерөнхий байдлын үзлэгт орсон ажилтны бүртгэл гарын үсэг.

Ажил хариуцагч, эмч бөглөх хэсэг */Би энэхүү ажлыг гүйцэтгэхэд бүх аюулгүйн шаардлагууд биелэгдсэн гэдгийг зөвшөөрч байна./*

№	Ажил гүйцэтгэх ажилтны овог нэр	Гүйцэтгэх үүрэг	АА-ны зааврын нэр, дугаар	Зааварчилгаа авсан ажилтны гарын үсэг	Эрүүл мэндийн үзлэг		Алко тест
					Цусны даралт	Эмчийн дүгнэлт	
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							

8. Дээрх шаардлагууд болон хяналтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлсэн ажил хариуцагч ажилтан:

Овог нэр:..... Албан тушаал:..... Гарын үсэг : .....

9. Хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих ХАБ-н ажилтан:

Овог нэр:..... Гарын үсэг : .....

10. Зөвшөөрлийг хаасан ажил хариуцагч ажилтан:

Овог нэр:..... Албан тушаал:..... Гарын үсэг : .....

11. Зөвшөөрлийн хуудас хүлээж авсан ХАБ-н ажилтан:

Овог нэр:..... Гарын үсэг : .....

Зөвшөөрлийн хуудас бүрэн гүйцэт бөглөгдөөгүй тохиолдолд хүчингүйд тооцно.

БАТЛАВ:
"АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН
ОРЛОГЧ ЗАХИРАЛ
Д.НОМИН

/ Номин /

ОГНОО: / 2023/01/13 /

БАТЛАВ:
ОРХОН АЙМГИЙН ХОТ
ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНБАЯР

/ Б.Оюун /

ОГНОО: / 2022/01/25 /

AIC
ACHIT IKHT LLC

ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ ГЭРЭЭ
№ 23/014-А.

2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

Энэхүү Хог хаягдал устгах гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г **НЭГ ТАЛААС** 2101017 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Өөрийн байр, Хот тохижуулах газар (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-ыг төлөөлж Хот тохижуулах газрын гэрээ хариуцсан ажилтан Б.Долгор,

НӨГӨӨ ТАЛААС 2788705 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1 Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар хаягт оршдог "Ачит-Ихт" ХХК (цаашид "Захиалагч" гэх)-ийг төлөөлж ХАБЭАБО-ын менежер Ж.Мөнхдархан (цаашид тус тусад нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) нар Иргэний хуулийг болон бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцсоноор байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн үйлдвэрийн ахуйн хог хаягдал болон уурын зуухнаас гарсан үнсний хаягдлыг хүлээн авч, цуглуулан, хадгалж, дарж устгах ажил (цаашид "Ажил" гэх)-ыг холбогдох хууль, дүрэм, журам, стандарт, норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх, Захиалагч нь төлбөр төлөхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль болон бусад хууль, дүрэм, журам, стандартад заасны дагуу зохицуулна.

1.3. Талууд Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээний харилцаа дуусгавар болно.

1.4. Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа нь 2023 оны 1-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл 1 жил байна. /Үйлдвэрийн сул зогсолтын үеийг тооцохгүй/.

1.5. Гэрээг байгуулснаас хойш ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хүртэл Гэрээний үнийн дүн болон хугацаанд өөрчлөлт оруулахгүй болохыг талууд харилцан тохиролцов.

1.6. Гүйцэтгэгч нь ажлыг хийж гүйцэтгэхдээ үйлдвэрлэлийн болон ажил гүйцэтгэж байгаа бусад этгээдийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүйгээр зохион байгуулна.

1.7. Ажлын байр, талбайд Захиалагчийн дотоод болон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллах, орон нутгийн байгууллага, оршин суугчдад хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.

1.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ талууд бүрэн биелүүлж, бие биенээ харилцан хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.

ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

2.1. Гэрээний төлбөр нь 1 м^3 хогийг дарж устгах 11,500 *(Арван нэгэн мянга таван зуун)* төгрөг байна. Энэхүү үнийн дүнд ачиж тээвэрлэх болон халдваргүйжүүлэх, устгахтай болон холбогдох бүх зардал, татвар, суутгал, НӨАТ багтсан болно.

2.2. Захиалагч нь хог хаягдлыг дарж устгах талбай дээр буулгасан тухай сарын мэдээлэл бүхий баримт, Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн 30 хоногт багтаан төлнө.

2.3. Гүйцэтгэгчийн төлбөр хүлээн авах дансны мэдээлэл:
Банкны нэр: Төрийн сан
Дансны дугаар: 100210100947

2.4. Захиалагч нь төлбөрийг Монгол Улсын Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд зааснаар "Төгрөг"-өөр гүйцэтгэнэ. Талууд зайлшгүй шаардлагатай тохиолдолд

гэрээгээр Төлбөр тооцоог гадаад валютаар хийх бол тухайн валютын ханшийг төлбөр төлөх өдрийн Монгол банкны ханшаар хөрвүүлж тооцно.

2.5. Төлбөр хийх өдөр нь амралтын өдөр, нийтээр амрах баяр ёслолын өдөртэй давхацсан тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр төлбөрийг төлнө.

ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР

3.1. Гэрээний ажил гүйцэтгэх газар: Орхон аймагийн Хот тохижуулах газрын харъяа Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил багийн Алтан булгийн толгой, Хотын Хог хаягдлын нэгсэн цэг.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь дараах эрхтэй:

4.1.1. Гүйцэтгэгчээс ажил гүйцэтгэх үйл явцтай холбоотой мэдээллийг тухай бүр шаардан авах;

4.1.2. Хог хаягдал ачиж, тээвэрлэх захиалгын дагуу ажил гүйцэтгэх үед Гүйцэтгэгчийн ажлын явцад хяналт хийх, шаардлага тавих;

4.1.3. Хууль тогтоомжид заасан бусад эрх

4.2. Захиалагч нь дараах үүрэгтэй:

4.2.1. Хог хаягдал дарж устгасны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

4.2.2. Гэрээнд заасан хугацаанд ажлын үр дүнг дагалдах бичиг баримт, мэдээллийн хамт заасан газарт хүлээн авах;

4.2.3. Хогийн цэг дээр хог хаягдал буулгаж буй машины жолоочид хогийн хэмжээг заасан цехийн тэмдэг бүхий талоныг хүлээлгэж өгөх;

4.2.4. Хогийн цэгт хаягдлыг буулгахдаа диспетчерийн заасан цэгт буулгах;

4.2.5. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй:

5.1.1. Ажил гүйцэтгэхтэй холбоотой шаардлагатай баримт мэдээллийг цаг алдалгүй Захиалагчаас шаардан авах;

5.1.2. Хог хаягдал дарж устгасны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах.

5.2. Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй:

5.2.1. Хог хаягдал дарж устгах цэгт Захиалагчийн хог хаягдлыг буулгахад зориулсан талбай бэлтгэх

5.2.2. Хог хаягдлыг тухай бүрд нь дарж устгах;

5.2.3. Ажлын талбай дахь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны асуудлыг бүрэн хариуцаж, ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацанд Гүйцэтгэгчийн буруугаас үүдэлтэй ажлын талбай дээр гарсан эрсдэлийг бие даан бүрэн хариуцаж, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөж ажиллах;

5.2.4. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, Гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон бол нэн даруй мэдэгдэх;

5.2.5. Хог ачсан тээврийн хэрэгслийн бүртгэлийн журналд Захиалагчаар гарын үсэг зурж, баталгаажуулалт хийгдсэн байх;

5.2.6. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ЗУРГАА. ХАРИЛЦАА ХОЛБОО

6.1. Гэрээгээр тохирсны дагуу аливаа мэдэгдэл, албан бичиг, бусад баримт бичгийг бичгээр үйлдэх бөгөөд биечлэн болон цахим шуудангаар эсхүл Талуудын эрх бүхий этгээдүүд зөвшөөрсөн бусад хэрэгсэл доорх хаягаар хүргүүлнэ.

6.1.1. ***"Захиалагч"-ийн хувьд***:

Нэр: "Ачит-Ихт" ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил -1 Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар

Үйлдвэр: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Үйлдвэрийн район

Утас: (+976)-75951199, Дотуур дугаар #216

И-мэйл: info@achit-ikht.mn

#	Овог нэр	Албан тушаал	Цахим шуудан	Гар утасны дугаар

1.	*Ж.Мөнхдархан*	ХАБЭАБО- ны менежер	munkhdarkhan@achit-ikht.mn	75951199-ext: 203
2.	*Л.Азжаргал*	Ахлах нягтлан бодогч	azjargal.l@achit-ikht.mn	75951199-ext: 204
3.	*Г.Нарангэрэл*	Байгаль орчны ажилтан	narangerel.g@achit-ikht.mn	75951199-ext: 216

6.1.2. ***"Гүйцэтгэгч"-ийн хувьд:***

Нэр: Орхон аймгийн хот тохижуулах газар

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум. Баянцагаан баг, Тосгон хот тохижуулах газар

Утас: 70358944, (+976)-99360164

6.2. Мэдэгдлийг талуудын аль нэг нь 5.1-д заасан хэлбэрээр хүргүүлсэн тохиолдолд хүлээн авсан гэж тооцно. Мэдэгдэл хүргүүлсэн хугацаа нь амралтын өдөр, нийтээр амрах, баяр ёслолын өдөртэй давхацсан тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр хүлээн авсанд тооцно.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай Тал бүрэн хариуцаж төлнө.

7.2. Гэрэний аль нэг тал нь дараах нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг цуцалж болно.

7.2.1. Ямар нэгэн үр дүн гарахгүй болох нь илт бол.

7.2.2. Гүйцэтгэгч гэрээгээр тогтоосон хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол;

7.2.3. Хоёр талын ашиг сонирхлын үүднээс онцгой үндэслэлээр нэн даруцй гэрээнээс татгалзах шаардлагатай бол.

7.3. Талууд Гэрээний 7.2-т заасан үндэслэлээр Гэрээг цуцалсан тохиолдолд буруутай тал төлөгдсөн төлбөрийг нөгөө талын дансанд 100% буцаан шилжүүлнэ.

7.4. Хог хаягдлыг Гүйцэтгэгчийн өмчлөлд шижүүлсэн үеэс эхлэн ажлын үр дүнтэй холбоотой эрсдэл Гүйцэтгэгчид шилжинэ.

7.5. Захиалагч гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээний нийт үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг хугацаа хэтрүүлсэн хоног тутмаар тооцож Гүйцэтгэгчид төлнө.

7.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээний нийт үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг хугацаа хэтэрсэн хоног тутмаар тооцож Захиалагчид төлнө.

7.7. Гэрээнд тусгагдаагүй нэмэлт ажил гарсан тохиолдод нэмэлт төсвөөр харилцан тохиролцож, бичгээр үйлдэн шийдвэрлэнэ.

7.8. Талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг Талын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх болон энэхүү гэрээг дангаар цуцлахыг хориглоно.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Талууд гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2. **Хэрэглэх хууль**: Энэхүү Гэрээний агуулга, тайлбар нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна. Талууд энэхүү Гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдод Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.3. **Нууцлал:** Талууд гэрээ байгуулсантай холбоотой шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, Талуудтай холбоотой бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (Үүнд: бүх төрлийн гэрээ, хэлцэл, үнийн санал гэх мэт)-ийг нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд эсвэл гэрээний нөгөө Талын эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар буюу бичгээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг 3 жилийн хугацаанд хүлээнэ.

8.4. **Давагдашгүй хүчин зүйл:** Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Талуудын аль нэг тал нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол энэ тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

8.5. **Хавсралт:** Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

8.6. **Нэмэлт, өөрчлөлт**: Энэхүү Гэрээнд болон Хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ талаар ажлын 14 /Арван дөрвөн/-өөс доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болсонд тооцно.

8.7. **Гэрээний нэгдмэл байдал:** Гэрээ нь Талуудын хооронд бичгээр үйлдэгдсэн бүх урьдчилсан тохиролцоо, мэдэгдэл, баталгаа болон хэлэлцээрийг орлох бөгөөд Гэрээ нь бүхэлдээ Гэрээгээр тохирсон харилцааг зохицуулсан үндсэн баримт бичиг болно.

8.8. **Түсгаар байдал:** Гэрээний аливаа заалт хууль бус буюу хүчин төгөлдөр бусад тооцогдсон нь Гэрээний бусад нөхцөлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

8.9. **Гэрээний хувь:** Энэхүү Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд Талууд гарын үсэг зурж, нөгөө Талдаа хүргүүлснээр баталгаажуулсанд тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"АЧИТ-ИХТ" ХХК
ХАБЭАБО-НЫ МЕНЕЖЕР
Ж.МӨНХДАРХАН

/ _____ /

Огноо: / 2023.01.11 /

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ОРХОН АЙМГИЙН ХОТ ТОХИЖУУЛАХ ТЭЭВЭР АЖ АХУЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА
Б.СУМЪЯА

/ _____ /

Огноо: / _____ /

ХУУЛЬЧ
Т.ЦЭДЭВДОРЖ

/ _____ /

Огноо: / 2023. 01. 13 /

ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ГЭРЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН Б.ДОЛГОР

/ _____ /

Огноо: / 2023. 01. 25. /

ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗРЫН ЭДИЙН ЗАСАГЧ Д.ДАВААНЯМ

/ _____ /

Огноо: / 2023.1.25 /

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 01

Орхон Чулуут голын сав газрын захиргаа -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /
2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах ОР-01 тоот дүгнэлтийг үндэслэн Орхон аймаг/нийслэл Баян - Өндөр сум/дүүргийн Баянцагаан баг Чилдэрийн рашаан байршилтай
/ хаяг /
Катодын эрдэс чилдэр
/ үйл ажиллагааны чиглэл /
чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа Алт - Ихт ХХК -д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /
Орхон аймаг/нийслэл, Баян - Өндөр сум/дүүргийн
..... байршилтай хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд 6750 мян.м³ хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015", "Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /
нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно. Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

Баян - Өндөр сумын ЗДТГ ..... / Б. Баясгалан /
/ Зөвшөөрөл олгосон байгууллага / / Гарын үсэг / / Гарын үсгийн тайлал /

Тамга

2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр

БАТЛАВ.
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД"ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
...../ Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ.
"АЧИТ-ИХТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
...../ Д.НОМИН /

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

2023 оны 07 сарын 07 өдөр №Т-23/ 084 Улаанбаатар хот
23/068.-А

Энэхүү гэрээ нь №Ш-23/084 , 23/.....-А тоот "Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээ"-ний салшгүй хэсэг байна.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас "Цэцүүх трейд"ХХК /цаашид Тээвэрлэгч гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, нөгөө талаас **Ачит-Ихт ХХК**-г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны менежер албан тушаалтай Ж.Мөнхдархан бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1,2-р хавсралт болох"Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам" , Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1.1 Энэхүү Гэрээгээр Тээвэрлэгч нь Тээвэрлүүлэгчийн даалгаврын дагуу Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багын нутаг дэвсгэрт орших "Ачит-Ихт" ХХК-с Аюултай хог, хаягдлын дагалдах бичиг заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т тээвэрлэн хүргэх ажлыг энэ Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх, зохих ёсоор хүлээлгэн өгөх, Тээвэрлүүлэгч нь тээврийн хөлсийг төлөх, талууд эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг №... тоот "Аюултай хог хаягдал шилжүүлэх" гэрээ, Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.

1.2 Тээвэрлэгч ачаа, бараг тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг баримтлана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Тээвэрлэлтийн гэрээний хугацаа 2023 оны 07 сарын 01-ний өдрөөс 2024 оны 07 сарын 01-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байна.

2.2 Энэ гэрээ хэрэгжиж эхлэх огнооноос эхлэн, гэрээний зүйлүүдийн дагуу хугацаанаас нь өмнө цуцлагдахаас бусад тохиолдолд, дуусгавар болох огноог дуусталх хугацаанд хүчин төгөлдөр байна.

2.3 Гэрээний хугацааг гагцхүү талууд харилцан зөвшилцөж, бичгээр зөвшөөрсөний үндсэн дээр өөрчилнө.

ГУРАВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАХИАЛГА

Хуудсыг баталгаажуулсан:

3.1 Тээвэрлүүлэгч аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх захиалгаа тээвэрлэгчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn мэйл хаягаар өгнө. Тээвэрлүүлэгч нь Захиалга өгөх бүртээ тээвэрлүүлэх аюултай хог хаягдал болох хуванцар сав, уут шуудайны хэмжээ, ширхэг, жингийн талаарх мэдээллийг тээвэрлэгчид өгнө.

3.2 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн өгсөн аюултай хог хаягдлын мэдээллийг харгалзан үзэж хавсралт №1-д дурдсан тээврийн хэрэгслүүдээсээ сонгож тухайн тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

3.3 Тээвэрлүүлэгч захиалгаа өгсөнөөр талууд тээвэрлэлтийн хуваарийг 2 хоногийн дотор харилцан тохиролцож гаргана. Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр тээвэрлэлтийн огноог хуанлийн 7 өдрөөр урагшлуулж, хойшлуулж болно.

3.4 Тээвэрлэлтийн хуваарь гарсанаас хойш тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт байрлах "Ачит-Ихт" ХХК-ээс Аюултай хог хаягдлын дагалдах бичгт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т талбай дээр гэрээний 3.3-т заасны дагуу товлосон захиалга өгсөн одорт очсон байна.

3.5 Тээвэрлэгч тээвэрлүүлэгчийн талбай дээр хүрэлцэн очсоноос хойш 5 цагийн дотор тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд дагалдах бичгт дурдсан аюултай хог хаягдлаа ачиж өгнө.

3.6 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчээс аюултай хог хаягдлыг хүлээн авч тээвэрлүүлэгчийн талбайгаас гарсанаас хойш ... цагийн дотор хүлээн авагчийн Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэж өгнө.

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТӨЛБӨР ТООЦОО

4.1 Гэрээний талууд бичгээр өөрөөр харилцан тохиролцоогүй бол тээвэрлүүлэгч талаас тээвэрлэгчээр ачаа тээвэрлүүлсэн төлбөрөө цаг тухайд нь гэрээний хавсралт №1-д тусгасан тарифаар тооцож төлнө.

4.2 Тээвэрлэлтийн хөлсийг дараахи нөхцөлөөр зохицуулна.

4.2.1 Тээвэрлүүлэгч нь аюултай хог хаягдлаа тээвэрлүүлж хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын 5 хоногийн дотор тээвэрлэгчийн нэхэмжлэхийн дагуу 100% төлбөрийг төлнө.

4.2.2 Төлбөр тооцоог тээвэрлэгчийн Голомт банк, "Цэцүүх трейд"ХХК, **1715132986** тоот дансаар шилжүүлнэ.

4.2.3 Дизель түлшний үнийн өсөх болон буурах 10 төгрөг тутамд нэг рейсийн үнэ 15000 төгрөгөөр нэмэгдэх буюу хасагдана. Өнөөдрийн үнэ 4030төгрөг

ТАВ. ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Тээвэрлэгчээр аюултай хог, хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргүүлэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүрэгтэй.

5.2 Аюултай хог, хаягдлыг тусгай зорилалт бүхий "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээ бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг тээвэрлэгчээс шаардах эрхтэй.

5.3 Тээвэрлүүлэгч аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид хүлээлгэн өгөхдөө Тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичгийн хамт ачиж өгнө.

5.4 Хог хаягдлын дагалдах бичгийг үнэн зөв бөглөсөн байх, хэрэв худал зөрүүтэй мэдээлсэнээс аюул, осол гарах, хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахгүй байх нөхцөл байдал үүсвэл хариуцлагыг тээвэрлүүлэгч хүлээнэ.

5.5 Тээвэрлүүлэгч буюу Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.

5.6 Аюултай хог хаягдлыг гэрээнд заасан газарт хүргэж, хүлээлгэн өгөх үед хүлээн авагч нь хог, хаягдлыг хүлээн авсан тухай гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан дагалдах бичгийн 2 дах хувийг тээвэрлэгчээс шаардан авах эрхтэй.

5.7 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчид аюултай хог, хаягдлын талаарх зохих мэдээлэл, зааварчилгаагаар бүрэн хангах үүрэгтэй.

5.8 Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэх үед хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээтэйгээ таарч байгаа эсэхийг хамтран шалгах үүрэгтэй. Хэрэв таарахгүй байвал ачих

Хуудсыг баталгаажуулсан:

аюултай хог хаягдлын мэдээллийг үнэн зөв агуулсан дагалдах бичгийг дахин үйлдэж тээвэрлэгчид өгнө.

5.9 Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүй байдлыг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.

5.10 Аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид зохих журмын хүлээлгэн өгч ачуулсанаар эрсдэл тээвэрлэгчид шилжинэ. Гагцхүү дагалдах бичгийг худал, зөрүүтэй бөглөсөн болон гэрээний 5.9-д заасан нөхцөл байдал үүссэнээс байгаль орчин, хүн, амьтан, эд хөрөнгөд хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.

ЗУРГАА. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэх үүрэгтэй.

6.2 Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй, хог хаягдлыг тээвэрлэх зорилалт бүхий бүхээгтэй байх ба зохих стандарт нөхцлийг хангасан эвдрэлгүй тээврийн хэрэгслээр аюултай хог, хаягдлыг тээвэрлэх үүрэгтэй.

6.3 Тээвэрлэгч нь хог хаягдлын дагалдах бичгийг бүрэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж хүлээн авна.

6.4 Тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо, хэмжээнд үл зохицол үүсвэл уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.

6.5 Тээвэрлэгч нь аюултай хог, хаягдлыг тээвэрлэхдээ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх ба замын хөдөлгөөний хууль, дүрмийг зөрчсөнөөс тээвэрлүүлэгчид болон бусдад учирсан хохирлыг тээвэрлэгч дангаар хариуцна.

6.6 Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэхтэй холбогдсон бусад зардлыг өөрөө дангаар хариуцна. / бензин, моторын тос, тээврийн хэрэгсэлд шаардлагатай сэлбэг, багаж хэрэгсэл, хоол хүнс/

6.7 Тээвэрлэгч аюултай хог, хаягдлыг хүлээн авснаас хойш хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хог хаягдал алдагдсан, дутсан, гэмтсэн, эвдэрсэн түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хожимдуулсан хариуцлагыг дангаар өөрийн эд хөрөнгөөр хариуцна.

6.8 Харин Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүйг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.

6.9 Дагалдах бичигт хавсаргасан буюу өөрөө хүлээн авсан баримт бичгийг үрэгдүүлсэн, буруугаар ашигласны хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

7.1 Тээвэрлүүлэгч нь энэ гэрээний 3-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд тээвэрлэгчид төлнө.

7.2 Тээвэрлэгч нь гэрээнд заасан үүргээ гүйцэтгээгүй буюу хүлээн авагчид аюултай хог, хаягдлыг хүлээлгэн өгөөгүй бол тээвэрлүүлэгчээс түүнд шилжүүлсэн аюултай хог, хаягдлаа эргүүлэн авах, боломжгүй бол шилжүүлсэн төлбөрөө буцаан шаардах эрхтэй.

7.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

НАЙМ. БУСАД ЗААЛТ

8.1 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.3 Гэрээний нэмэлт, оорчлолт нь зөвхөн бичгээр хийгдэж Талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

Хуудсыг баталгаажуулсан:

8.4 Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:

Ачит-Ихт ХХК-ийн
ХАБЭАБО-ны менежер

_____ / Ж.Мөнхдархан /

Суурин утас: 75951199
Гар утас: 85000801
Регистер: 2788705
УБ гэрчилгээний дугаар: 9011190055
Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар:
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил 1, Чингисийн оргон чөлөө-6, Кэй Би Тауэр 21 давхар.
Email хаяг: contact@achit-ikht.mn
munkhdarkhan@achit-ikht.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга

_____ Б.Дарамбазар /

Суурин утас: 70189778
Гар утас: 99057786
Регистер: 2066521
УБ гэрчилгээний дугаар: 9011026056
Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр
Email хаяг: Darambazar@tsetsuuh.mn
Шуудангийн хаяг: ШХ-1138

_____ Хуудсыг баталгаажуулсан: _____

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ҮНИЙН САНАЛ

№	Авто машины нэр төрөл, даац	Авто машины зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ /Төг/
1	Хүнд даац : 25-30 тонн Машины марк: Nord benz, DAP		1км	4 900 төг
2	Бага даац : 3 тонн Машины марк: ISUZU		1км	2 900 төг
3	Бага даац : 1 тонн Машины марк: Bongo Fronter		1км	2 400 төг

Тайлбар:
Дээрх тээвэрлэлтийн хөлсөд НӨАТ орсон үнэ болно.

1. НУБ 2020 оны аргачлал, Монгол улсын химийн бодисын тухай хууль, Монгол улсын хмиийн аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой MNS4978:2000 стандарт, аюултай ачаа тээвэрлэх хууль, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр маршрутын дагуу хөлдөлмөр аюулгүй ажилагааг ханган тээвэрлэнэ.
2. Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж Аюултай хог хаягдлын савыг зохих журмыг дагуу бүрэн сулласан байх, хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын дагуу заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуудсыг баталгаажуулсан:

"АЧИТ-ИХТ" ХХК-н АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ МАРШРУТ БОЛОН ҮНИЙН САНАЛ

№	Машины марк даац	Нэг удаагийн тээвэрлэлтийн маршрут	Нийт км	Нэгж үнэ /тог/	Нийт үнэ /тог/
1	/тээврийн хэрэгсэл сонгох/ Тээвэрлэлт хийх давтамж: 1удаа	"Ачит-Ихт" ХХК-н захналгын дагуу Орхон аймаг, Баянцагаан баг, Үйлдвэрийн Район хаягтай байршлаас аюултай хог хаягдлыг тээвэрлэн /Төв аймаг Сэргэлэн сум 4- зөрлөг/ нутаг дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэх.	2 талд нийт .....км	.....тог	.....тог
	Нийт дүн: ..... төгрөг				**т**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:

Ачит-Ихт ХХК-ийн
ХАБЭАБО-ны менежер

/ Ж.Мөнхдархан /

Суурин утас: 75951199
Гар утас: 85000801
Регистер: 2788705
УБ гэрчилгээний дугаар: 9011190055
Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар:
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил 1, Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би Тауэр 21 давхар.
Email хаяг: contact@achit-ikht.mn
munkhdarkhan@achit-ikht.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:

Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн дарга

/ Б.Дарамбазар /

Суурин утас: 70189778
Гар утас: 99057786
Регистер: 2066521
УБ гэрчилгээний дугаар: 9011026056
Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр
Email хаяг: Darambazar@tsetsuah.mn
Шуудангийн хаяг: ШХ-1138

Хуудсыг баталгаажуулсан:

БАТЛАВ.
"ЦЭЦҮҮХ ТРЕЙД" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ.
"АЧИТ-ИХТ"ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Д.НОМИН/

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 07 сарын 07-ны өдөр № Ш-23/084 Улаанбаатар хот
23/262-А

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, Нөгөө талаас **Ачит-Ихт ХХК**-г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны менежер албан тушаалтай Ж.Мөнхдархан бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын ***2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал*** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.

1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.

2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.

2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.

2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ ***БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг*** бүрдүүлж өгнө.

2.5. Аюултай хог хаягдлын *савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон үүсмэлээр цэвэрлэсэн байна.* Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуудсыг баталгаажуулсан:

2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

